

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН
ТАЙЛАН

2019-2022 онуудад хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх ажилд
төсвийн 60.0 орчим хувийг хуваарилан зарцуулж байсан бол
2023 онд хариу үйлчилгээнд батлагдсан төсвийн 73.0 хувийг зарцуулсан байна.

АУДИТЫН СЭДЭВ: ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТАЛЖ БУЙ
БОДЛОГО, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: СЭА-2024/20-17-ШТА-ГА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Сүхбаатар сум	Дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа	
	Утас: 70363040	Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn
	Аудитын менежер	Б.Батмөнх
2024 он	Утас: 70363036	Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn
	Ахлах аудитор	С.Баасансүрэн
	Утас: 70363036	Цахим хаяг: Baasansurens@audit.gov.com
	Аудитор Ж.Цогт	Цахим хаяг: Tsogtj@audit.gov.mn

Товчилсон үгийн тайлбар	2
Хүснэгтийн товъёг	2
Дүрслэлийн товъёг	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	3
Ерөнхий мэдээлэл	4
1 бүлэг: Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, тогтолцоо оновчтой хэдий ч хэрэгжүүлэгч байгууллагуудын өөр хоорондын уялдаа холбоог хангаж ажиллаагүй байна.	5
1.1. Монгол Улсын хөгжлийн урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан аймгийн хөгжлийн дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт хүүхэд хамгааллын зорилт, арга хэмжээг тусган хэрэгжүүлж байна.	5
1.2. Аймгийн ХГБХХГ нь Хүүхдийн төлөө зөвлөл, Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны “Ажлын алба”-ны үүргийг өөр хооронд нь уялдуулаагүй, хангалтгүй гүйцэтгэсэн байна.	7
2 бүлэг: 2019-2022 онуудад хүүхэд хамгааллын зардлын дийлэнх хувийг урьдчилан сэргийлэх ажилд зарцуулж байсан бол 2023 онд батлагдсан төсвийн 73.0 хувийг хариу үйлчилгээнд зарцуулсан байна.	13
2.1. Нөхцөл байдлын үнэлгээ хийсэн, хариу үйлчилгээ үзүүлсэн нийгмийн ажилтан, хамтарсан багийн гишүүдэд олгох урамшууллыг тооцож, төлөвлөөгүй байна.	13
2.2. Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээнд батлагдсан төсвийг урьдчилан сэргийлэх ажилд гүйлгэн зарцуулсан боловч гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.	16
3 бүлэг: Хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд оролцогч талуудын хэрэгжүүлж буй үйл ажиллагааг нэгтгэх, үнэлэх ажил хангалтгүй байна.	21
3.1. Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөл нь хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.	21
3.2. Зарим салбарт хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт хангалтгүй байна.	24
3.3. Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байгаа хэдий ч хүүхдийн эсрэг гэмт хэргийн тоо нөлөөлөхүйцээр буурахгүй, бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоо 2023 онд өмнөх оноос бараг 5 дахин өссөн байна.	29
Илрүүлсэн зөрчил	34
Дүгнэлт	34
Зөвлөмж	34
Ирүүлсэн санал, тайлбар	36

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ГХУСАЗЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх аймгийн зохицуулах зөвлөл
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУ	Монгол Улс
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
ОУБ	Олон улсын байгууллага
УИХ	Улсын Их Хурал
ХГБХХГ	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар
ХЗДХ	Хууль зүй, дотоод хэрэг
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХНХ	Хөдөлмөр нийгмийн хамгаалал
ХТҮГ	Хүүхдийн төлөө үндэсний газар

Хүснэгтийн товъёг

Д/д	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Able системд бүртгэж буй мэдээлэл-1	11
Хүснэгт 2	Able системд бүртгэж буй мэдээлэл-2	12
Хүснэгт 3	Төсвийн төсөл болон батлагдсан төсөв	14
Хүснэгт 4	Хүүхэд хамгааллын үйл ажиллагааны төсвийн төлөвлөлт	15
Хүснэгт 5	Хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд батлагдсан төсөв	17
Хүснэгт 6	Сургалтын тоо болон зарцуулсан зардал	17
Хүснэгт 7	Шилэн дансанд мэдээлсэн байдал	18
Хүснэгт 8	Урьдчилсан сэргийлэх ажил болон хамгааллын хариу үйлчилгээний харьцуулалт	20
Хүснэгт 9	Олон нийтийн арга хэмжээ, соёл спортын үйл ажиллагааны үеэр эрх зөрчигдсөн хүүхдийн тоо	28
Хүснэгт 10	108 дугаарт ирсэн дуудлага мэдээлэл хүчирхийллийн төрлөөр	31
Хүснэгт 11	Насанд хүрээгүй хүүхдийн оролцсон гэмт хэргийн тоо	33

Дүрслэлийн товъёг

Д/д	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Иргэдийн саналын дүн	24
Дүрслэл 2	Гэр бүлийн орчин дахь хүүхдийн эрхийн зөрчил	25
Дүрслэл 3	Иргэдийн саналын дүн	32

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ	
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны “Аудитын сэдэв батлах тухай” 08 дугаар тогтоол, Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний дагуу хийж гүйцэтгэлээ.
Аудитын зорилт:	Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилго оршлоо. Уг зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: ➤ Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, төлөвлөлтийн тогтолцоо оновчтой эсэх, ➤ Хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөлт, төсөвлөлт үр өгөөжтэй, хүүхдэд ээлтэй байж чадсан эсэх, ➤ Хүүхэд хамгааллын талаар баримталж буй бодлогын хэрэгжилт, үр дүнтэй эсэх.
Аудитын хамарсан хүрээ:	Хүүхэд хамгааллын тухай хуулийн хүрээнд хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд оролцдог төрийн болон төрийн бус байгууллагуудын 2019-2023 оны баримт, мэдээллийг хамруулан аудитыг гүйцэтгэлээ.
Аудитын арга зүй:	Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, судалгаа явуулах, ярилцлага хийх арга зүйг ашиглан гүйцэтгэлээ.
Аудитын шалгуур, үзүүлэлт:	Аудитад дараах шалгуур үзүүлэлтийг ашиглалаа. Үүнд: • Хүүхдийн эрхийн тухай конвенц, • Монгол Улсын Үндсэн хууль, • Хүүхэд хамгааллын тухай хууль, • Хүүхдийн эрхийн тухай хууль, • Гэр бүлийн тухай хууль, • Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, • Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, • Боловсролын тухай хууль, • Төсвийн тухай хууль, • Шилэн дансны тухай хууль,

	• УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, • УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, • Засгийн газрын 2002 оны 245 дугаар тогтоолоор баталсан “Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр”, • Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор баталсан “Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого, чиглэл”, • Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2020 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” болон холбогдох бусад баримт материалууд.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа:	Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор С.Баасансүрэн, аудитор Ж.Цогт нар 2024 оны 08 дугаар сарын 29-ний өдрөөс 10 дугаар сарын 25-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.
Ерөнхий мэдээлэл:	Хүүхэд хамгааллын чиглэлээр аймгийн ИТХ-ын 2020 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Сэлэнгэ аймгийн 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө”-нд 5, 2021 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Сэлэнгэ аймгийн 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө”-нд 4, 2022 оны 83 дугаар тогтоолоор баталсан “Сэлэнгэ аймгийн 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө”-нд 6 арга хэмжээг тус тус тусган баталсан байна. Аймгийн Засаг даргын захирамжаар “Сэлэнгэ аймгийн Хүүхдийн төлөө зөвлөл”-ийг байгуулсан бөгөөд тус зөвлөлийн “Ажлын алба”-ны чиг үүргийг аймгийн ХГБХХГ нь гүйцэтгэж байна. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2022 оны А/62 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар Сэлэнгэ аймгийн ХГБХХГ-ын зохион байгуулалтын 5 нэгжид 23, Мандал сумын Хүүхдийн ордон 12, Орхонтуул сумын Хүүхдийн хөгжлийн төв 3, Мандал, Сүхбаатар сумын түр хамгаалах байрны нийгмийн ажилтан 5 зэрэг нийт 43 орон тоог баталсан байна.

Бүлэг 1

Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, тогтолцоо оновчтой эсэх?

Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, тогтолцоо оновчтой хэдий ч хэрэгжүүлэгч байгууллагуудын өөр хоорондын уялдаа холбоог хангаж ажиллаагүй байна.

1.1 Хүүхэд хамгааллын бодлого, тогтолцоо нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн үү?

Монгол Улсын хөгжлийн урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан аймгийн хөгжлийн дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт хүүхэд хамгааллын зорилт, арга хэмжээг тусган хэрэгжүүлж байна.

1.1.4. Аудитын явцад хүүхэд хамгааллын талаар мөрдөж буй дараах хууль, тогтоомж, урт дунд хугацааны бодлогын баримт бичиг хоорондын уялдаа, холбоо хангагдаж байгаа эсэхийг тулган шалгаж, үнэлэлт дүгнэлт өглөө. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль,
- Хүүхэд хамгааллын тухай хууль,
- Хүүхдийн эрхийн тухай хууль,
- Гэр бүлийн тухай хууль,
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль,
- Алсын хараа-2050,
- Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр,
- Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр,
- Сэлэнгэ аймгийн 2020-2023 онуудын хөгжлийн жилийн төлөвлөгөө гэх мэт.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2-т “Хүүхэд хамгаалал нийгмийн бүх орчинд хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэрээс, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэх зорилготой олон талт, цогц, мэргэшсэн үйл ажиллагаанаас бүрдэнэ” гэж заасан байдаг.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050” -ийн “Хүний хөгжил” бүлгээс гадна Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 2 дугаар зүйлийн 2.5.8-д “Гэр бүл, хүүхэд залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг дээдэлсэн, нийгмийн бүх бүлгийн оролцоог хангасан хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлнэ” гэж хүүхэд, залуучууд, гэр бүл, нийгэмд чиглэсэн үндсэн бодлогыг тодорхойлсон байна.

Дээрх хууль тогтоомж, МУ-ын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдийг үндэслэн аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 13 дугаар тогтоолоор баталсан “Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2 дугаар зүйлийн 2.5-д хүүхэд, гэр бүлийн чиглэлээр дараах 4 зорилтыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн

- 2.5.1.Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг бүх шатанд зохион байгуулж, “Хүчирхийлэлгүй аймаг” болох бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.5.2.Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд гэр бүл төлөвлөлтийн талаарх мэдлэг, мэдээллийг олгох ажлыг зохион байгуулна.
- 2.5.3.Хүүхдийг болзошгүй эрсдэл, осол гэмтэл, гэмт хэрэг, цахим орчны нөлөөллөөс урьдчилан сэргийлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 2.5.4.Хүүхдийн хүмүүжил төлөвшлийн асуудалд онцгой анхаарч, гэр бүлийн гишүүн бүрд зориулсан нөлөөллийн ажлыг зохион байгуулж, эцэг, эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлнэ.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан баталсан Сэлэнгэ аймгийн 2021, 2022, 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнүүдэд хүүхэд хамгаалал, гэр бүлийн чиглэлээр тус бүр 4-6 арга хэмжээг тусган баталж, хэрэгжилтийг ханган, жил бүр тайлагнаж ирсэн байна.

Өөрөөр хэлбэл Монгол Улсын хөгжлийн урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээг аймгийн хөгжлийн дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусган хэрэгжүүлж байна.

1.1.6. Хүүхдийн хөгжил, хамгааллыг үе шаттай сайжруулах зорилгоор Засгийн газрын 2002 оны 245 дугаар тогтоолоор “Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр”, 2017 оны 270 дугаар тогтоолоор “Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр”-ийг 2017-2021 онд хэрэгжүүлэхээр тус тус баталсан байна.

2017 оны дээрх хөтөлбөрийг дараах 5 зорилтын хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

- “Хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангасан хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлнэ.”
- “Хүүхэд бүрийг хөгжүүлэх таатай орчныг бүрдүүлж, хүүхдийн авьяас, чадварыг нээн хөгжүүлнэ.”
- “Хүүхдийг сонсох, үзэл бодлыг нь хүндэтгэх нийгмийн хандлагыг төлөвшүүлж, бодлого төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх үйл явцад хүүхдийн оролцоог нэмэгдүүлнэ.”
- “Нийгмийн бүх орчинд хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэр, эрсдэлт нөхцөлд өртөхөөс хамгаална.”
- “Тэгш боломж олгох нийгмийн хамгааллыг дэмжих замаар хүүхдийн орлогын болон орлогын бус ядуурлыг бууруулна.”

Тус хөтөлбөрийн хэрэгжилтийг ХНХ-ын сайдын 2017 оны А/121 дүгээр тушаалаар баталсан “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын үйл ажиллагааг үнэлж, дүгнэх журам”, ГБХЗХГ-ын даргын 2019 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн А/08 дугаар тушаалаар баталсан “Гэр бүл, хүүхэд, залуучуудын байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу үнэлж, хяналт-шинжилгээ хийсэн байна. Үүнд:

- 2018-2019 онд 5 зорилт, 43 арга хэмжээг төлөвлөж, гүйцэтгэлээр 43 хувь,
- 2019-2020 онд 5 зорилт, 13 арга хэмжээг төлөвлөж, гүйцэтгэлээр 96 хувь,
- 2020-2021 онд 5 зорилт, 13 арга хэмжээг төлөвлөж, гүйцэтгэлээр 100 хувьтай буюу “бүрэн хэрэгжсэн” гэж үнэлж, дүгнэсэн.

Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн

Өөрөөр хэлбэл “Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр”-ийн эхний үе шатны хэрэгжилт хангалтгүй байсан бол 2 дугаар үе шатанд төлөвлөсөн хугацаанд нь бүрэн хэрэгжүүлсэн гэж үнэлж, дүгнэсэн байна.

1.2 Хүүхэд хамгааллын үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагууд хүний нөөцийн хүртээмжтэй байдлыг хангаж, харилцан уялдаатай ажиллаж чадаж байна уу?

Аймгийн ХГБХХГ нь Хүүхдийн төлөө зөвлөл, Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны “Ажлын алба”-ны үүргийг өөр хооронд нь уялдуулаагүй, хангалтгүй гүйцэтгэсэн байна.

1.2.2. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т хүүхэд гэр бүлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагын чиг үүргийг тогтоосон байдаг.

Аудитад хамрагдаж буй 2019-2023 онд аймгийн ХГБХХГ нь дээрх хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1-18.2.7-д заасан чиг үүргийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж, тайлагнасан байна. Үүнд:

18.2.1-д заасны дагуу аймгийн хэмжээнд хүүхэд хамгааллын талаарх авч хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээг тодорхойлж 2019 онд 6 зорилтын хүрээнд 38, 2020 онд 16 зорилтын хүрээнд 99, 2021 онд 4 зорилтын хүрээнд 43, 2022 онд 4 зорилтын хүрээнд 43, 2023 онд 4 зорилтын хүрээнд 50 арга хэмжээг тус тус төлөвлөж, хэрэгжилтийг тайлагнасан, 18.2.4-т заасны дагуу хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах сургалтыг 2019 онд 4 удаа, 2020 онд нөхцөл байдлын үнэлгээ хийх сургалтыг 1 удаа, 2021 онд цахим сургалтыг 1 удаа, 2022 онд 2 удаагийн сургалтыг зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр ханган ажилласан, 18.2.5-д заасны дагуу эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаарх мэдээллийн сан бүрдүүлж 2019 онд 600, 2020 онд 751, 2021 онд 751, 2022 онд 590, 2023 онд 609 хүүхдийн мэдээллийг программд оруулж, хариу үйлчилгээ үзүүлсэн тайланг ХГБХХГ-т хүргүүлсэн, 18.2.6-д заасны дагуу гэр бүлийн хүчирхийллийн зөрчил гаргасан 2019 онд 75, 2020 онд 40, 2021 онд 45, 2023 онд 67 иргэнийг “Архинд донтолт, түүний хор уршиг, уур бухимдлыг хэрхэн зохицуулах”, “Архины донтолт ба хор уршиг” сэдэвт сургалтуудад хамруулсан байна.

Сэлэнгэ аймгийн ХГБХХГ нь хуульд заасан дээрх чиг үүргийг буюу 2019-2023 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г бүрэн хэрэгжүүлсэн гэж үзэж дээд шатны байгууллагаас дараах байдлаар үнэлсэн байна. Үүнд:

ГБХЗХГ-ын даргын 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/12 дугаар тушаалаар 89.0, ГБХЗХГ-ын даргын 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/06 дугаар тушаалаар 93.3, ГБХЗХГ-ын даргын 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/92 дугаар тушаалаар 91.9, ГБХЗХГ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/257 дугаар тушаалаар 93.9, ГБХЗХГ-ын даргын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/204 дүгээр тушаалаар 92.2 хувиар тус тус үнэлсэн.

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.2¹-т заасны дагуу аймгийн Засаг даргын 2017 оны А/44 дүгээр захирамжаар “Хүүхдийн төлөө зөвлөл”-ийн бүрэлдэхүүн, дүрмийг баталсан бол 2023 оны А/434 дүгээр захирамжаар бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан байна.

¹ Зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийн байгууллага, хуулийн этгээд, иргэдийн төлөөлөл оролцох бөгөөд бүрэлдэхүүнийг зөвлөлийн тэргүүн батална.

Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн

Тус хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь “Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөлийн ажлын албаны үүргийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тус тус чиг үүргийн дагуу хэрэгжүүлнэ” гэсэн заалтын дагуу аймгийн ХГБХХГ нь зөвлөлийн ажлын албаны үүргийг гүйцэтгэж ирсэн бөгөөд тус газрын даргыг “Хүүхдийн төлөө зөвлөл”-ийн ажлын албаны дарга буюу нарийн бичгийн даргаар томилон ажиллуулсан байна.

Аудитын явцад аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагааг түүвэрчлэн авч үзэхэд Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.1-16.4.3-т заасан чиг үүргийн дагуу дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Аймгийн Засаг даргын “Хүүхэд хамгааллын болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай” 2019 оны А/169 дүгээр захирамжаар 4 чиглэлийн үүрэг өгч, ажлыг эрчимжүүлэхийг даалгаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.
- Аймгийн Засаг даргын 2022 оны А/47 дугаар захирамжаар “Дэлгэцийн донтолтоос сэргийлж, эрүүл мэндээ хамгаалцгаая” аяныг хэрэгжүүлэх нэгдсэн төлөвлөгөө, болзолт уралдааныг зарлан, хэрэгжилтийг хангуулж ажилласан байна.
- Аймгийн Засаг даргын 2022 оны А/181 дүгээр захирамжаар сордог электрон тамхийг 21 нас хүрээгүй хүнд худалдан борлуулахыг хориглож, хэрэгжилтэд аймгийн Цагдаагийн газар, МХГ, БШУГ-аас хяналт тавьж ажиллахыг даалган, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.
- Аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар захирамжаар төр, төсвийн байгууллагын дарга, сумдын Засаг дарга, тосгодын захирагч нарт болон эцэг, эх, асран хамгаалагч нарт хүүхдийн эрхийг хамгаалах, эрх зөрчигдөх, эрүүл аюулгүй орчинд амьдрах, аливаа хүчирхийлэл дарамтаас ангид байх, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор албан даалгавар хүргүүлсэн,
- Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газраас баталсан удирдамжийн дагуу жил бүр “Оны онцлох хүүхэд”-ийг шалгаруулан шагнаж, урамшуулсан байна.
- Хүүхдийн сурч боловсрох орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар:
 - 2022 онд ерөнхий боловсролын 2 сургуульд нийт 70.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 5 сургууль, 1 цэцэрлэгийн барилгын зэрэг нийт 526.5 сая төгрөгийн их засварын ажлыг гүйцэтгэсэн,
 - 2023 онд ерөнхий боловсролын 4 сургуульд нийт 125.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 2 сургууль, 1 дотуур байр, 4 цэцэрлэгийн барилгын зэрэг нийт 756.6 сая төгрөгийн их засварын ажлыг гүйцэтгэсэн гэх мэт.

Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөл нь холбогдох хууль, журмын хүрээнд үйл ажиллагаагаа хэвийн хэрэгжүүлж байгаа боловч түүний “Ажлын алба” болох аймгийн ХГБХХГ-ын үйл ажиллагааг холбогдох нотлох баримтын хүрээнд тулган шалгахад дараах зөрчил оршиж байлаа. Үүнд:

- Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн дүрмийн 5.1², 5.2³-т зааснаар үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь зөвлөлийн хурал бөгөөд хагас жил тутамд нэг удаа хуралдахаар зохицуулсан боловч аудитад хамрагдаж байгаа 2019-2022 онуудад хуралдсан эсэх нь тодорхойгүй, хурлын тэмдэглэлээр баталгаажуулаагүй бөгөөд 2023 оны 1 удаагийн хурлыг тэмдэглэлээр баталгаажуулсан байна.
- Ажлын алба нь зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулж, үйл ажиллагааны тухайн жилийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг хангаж,

² Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал байна.

³ Зөвлөлийн ээлжит хурлыг хагас жилд нэгээс доошгүй удаа хуралдуулах ба шаардлагатай тохиолдолд хурлыг зарлан хуралдуулна. ...

тайлагнах, зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр зохицуулсан боловч 2019, 2020, 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж батлуулаагүй, хэрэгжилтийг тайлагнаагүй байна.

- Харин 2022, 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, зөвлөлийн тэргүүнээр батлуулан 2022 оны зорилтыг 97.0 хувийн, 2023 оны зорилтыг 90.0 хувийн хэрэгжилттэй гэж үнэлсэн боловч зөвлөлийн хуралд танилцуулж, хэлэлцүүлээгүй байна.
- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2020 оны А/240 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу ажлын албанаас аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн 2021 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 65.0 хувь буюу “Хангалтгүй” гэж дүгнэсэн боловч зөвлөлийн хуралд танилцуулж, баталгаажуулаагүй, үнэлгээний мөрөөр арга хэмжээ аваагүй байна.
- Зөвлөлийн үйл ажиллагааны дүрэмд заасны дагуу зөвлөл нь жил бүрийн 3 дугаар улиралд багтаан хүүхэд хамгааллын тайлан гаргаж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар төрийн байгууллагад чиглэл, нутгийн өөрөө удирдах байгууллага, холбогдох бусад байгууллагад зөвлөмж өгч, бодлого тодорхойлох, шийдвэр гаргах эрх бүхий оролцогч талуудад санал оруулах ажил хийгдээгүй байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1⁴-д заасны дагуу аймгийн Засаг даргын 2017 оны А/244 дүгээр захирамжаар “Сэлэнгэ аймгийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо”-г 11 хүний бүрэлдэхүүнтэй анх байгуулсан бол 2022 оны А/19 дүгээр захирамжаар 17, 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/05 дугаар захирамжаар 15 гишүүнтэйгээр тус тус шинэчлэн баталсан байна.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, ХЗДХ-ийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/190/А/280 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам”-ын 3.7⁵-д зааснаар аймгийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны нарийн бичгийн дарга бөгөөд “Ажлын алба”-ны даргаар ГБХЗХГ /тухайн үеийн нэршилээр/ -ын даргыг томилсон байна.

Аудитын явцад Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааны үр дүнг тулган баталгаажуулахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- 2019 онд 82, 2020 онд 46, 2021 онд 18, 2022 онд 13, 2023 онд 15 зэрэг нийт 174 хүүхдэд хууль, эрх зүйн үйлчилгээ үзүүлсэн гэж тайлагнасан боловч санхүүжилт гарсан үйлчилгээнүүдийг нотлох баримтаар баталгаажуулсан бол үнэ төлбөргүй зөвлөгөө өгсөн ажлууд нь нотлох баримтаар бүрэн нотлогдохгүй байна.
- Тус хорооны 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 1 хуралдааны явцыг тэмдэглэлээр баталгаажуулсан бөгөөд бусад хуралдаан нь хурлын тэмдэглэлээр баталгаажуулаагүй байна.
- Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо нь 2022 онд 3 зорилт, 22 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн даргаар батлуулаагүй байгаа нь Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион

⁴ Аймаг, дүүргийн Засаг дарга орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай зөвшилцөн хүүхдийн эрхийн хууль зүйн хороог байгуулах ...

⁵ Хууль зүйн хорооны нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга нь аймаг, дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан газар /хэлтэс/-ын дарга байна.

Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн

байгуулалт, үйл ажиллагааны журмын 4.4.2⁶ дахь заалтыг зөрчсөн байна. Уг төлөвлөгөөний хэрэгжилтийг 53.1 хувиар үнэлж, тайлагнасан боловч үнэлгээний мөрөөр арга хэмжээ аваагүй байна. Тайлагнасан ажлын 5 нь хэрэгжилтийн нотлох баримтаар баталгаажсан бол 12 нь нотлох баримтаар баталгаажаагүй байна.

- Харин 2023 онд 3 зорилт, 19 арга хэмжээ бүхий жилийн төлөвлөгөөг боловсруулж, аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн даргаар батлуулсан бөгөөд хэрэгжилтийг 63.1 хувиар үнэлж, тайлагнасан боловч үнэлгээний мөрөөр арга хэмжээ аваагүй байна. Тайлагнасан ажлын 5 нь хэрэгжилтийн нотлох баримтаар баталгаажсан бол 11 нь нотлох баримтаар баталгаажаагүй байна.
- Дээрх журам хэрэгжсэнээс хойш буюу 2022, 2023 оны үйл ажиллагааны тайланг Хүүхдийн төлөө зөвлөлд тайлагнаагүй байна. Энэ нь ХНХ-ын сайд, ХЗДХ-ийн сайдын 2021 оны А/190/А/280 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам”-ын 4.13⁷ дахь заалтыг зөрчсөн байна.

Дээрхээс үзэхэд аймгийн хүүхэд хамгааллын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх үүрэг бүхий Хүүхдийн төлөө зөвлөл, Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны “Ажлын алба”-ны үйл ажиллагаа хангалтгүй байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Аймаг, сум, нийслэл дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ, 18.1.5: сум, хороонд хамтарсан баг байгуулах, үйл ажиллагаанд нь хяналт тавих” гэж заасан байдаг.

Хамтарсан баг нь хүүхэд, гэр бүлийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, үйлчилгээний хугацаатай хөтөлбөр, төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангахаас гадна хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй гэр бүлийг илрүүлэх, мэдээлэх, хүчирхийллийг таслан зогсоох, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах үүрэгтэй.

Сумдын ИТХ-ын тогтоолоор Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4⁸, 20 дугаар зүйлийн 20.1⁹-д заасны дагуу “Хамтарсан баг” -ийг байгуулсан бөгөөд аймгийн хэмжээнд 17 сумын 38 хамтарсан багт нийт 245 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Аудитын явцад Сүхбаатар сумын 8 багийн “Хамтарсан баг”-ийн үйл ажиллагааг түүвэрлэн тулган шалгахад эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдийг холбон зуучлах чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- 4, 8 дугаар багийн “Хамтарсан баг” нь 5 хүүхдийг эмчийн үзлэгт хамруулан, тус сумын 3 дугаар цэцэрлэгийн 24 цагийн ангид хүмүүжүүлэхээр холбон зуучилсан,

⁶ Хууль зүйн хорооны хуралдаанаар дараах асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэнэ: Хууль зүйн хорооны үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг хэлэлцэж, холбогдох шатны Хүүхдийн төлөө зөвлөлөөр батлуулах.

⁷ Хууль зүйн хороо үйл ажиллагааны тайланг хагас жил тутам нэг удаа аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж, жилд нэг удаа орон нутгийн Хүүхдийн төлөө зөвлөлд тайлагнана.

⁸ “Хамтарсан баг” гэж хохирогч, түүний гэр бүлийн гишүүнд энэ хуулийн 37, 38.1.1, 40, 41, 42 дугаар зүйлд заасан үйлчилгээг хамтран үзүүлэх сум, хорооны Засаг даргаар ахлуулсан зохион байгуулалтын хэлбэр гэж ойлгоно.

⁹ Хамтарсан баг нь өрхийн эмч, сум болон хорооны нийгмийн ажилтан, сургуулийн, нийгмийн халамжийн болон хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, цагдаагийн алба хаагч, энэ чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдэх бөгөөд хамтарсан багийг тухайн сум, баг, хорооны Засаг дарга ахална.

Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн

- 5 дугаар багийн “Хамтарсан баг” нь 2 хүүхдийг тус сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуульд холбон зуучилж дотуур байранд амьдарч суралцах боломжийг бүрдүүлсэн байна.

Аудитын явцад Баянгол сумын 5, Ерөө сумын 5, Мандал сумын 25, Сант сумын 5, Сайхан сумын 5, Сүхбаатар сумын 23, Цагааннуур сумын 5, Дулаанхаан тосгоны 7 зэрэг нийт 80 тохиолдлыг түүвэрлэж үзэхэд анхан шатны баримтын бүрдэл дутуу дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- “Хамтарсан багийн үйлчилгээний төлөвлөгөө” Маягт ХБ 01-ийг огт бөглөөгүй 26, багийн гишүүдийн гарын үсгээр баталгаажуулаагүй 10 / Мандал, Сант, Сайхан, Сүхбаатар, Цагааннуур сум, Дулаанхаан тосгон/ хувийн хэрэг байна,
- “Хувийн хэрэг хаах” Маягт ХБ 05-ыг огт бөглөөгүй 14 /Мандал, Сант, Сайхан, Сүхбаатар, Цагааннуур сум, Дулаанхаан тосгон, / байна.

Түүвэрт хамрагдсан Мандал, Сант, Сайхан, Цагааннуур сум, Дулаанхаан тосгоны хамтарсан багууд нь багийн хурлыг тэмдэглэл, оролцогсдын гарын үсгээр баталгаажуулаагүй байгаа нь “Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам”-ын 3.1.5¹⁰ дахь заалтыг зөрчсөн байна.

Хэдийгээр хамтарсан багуудын үйл ажиллагаа хууль, журмын хүрээнд хэвийн явагдаж байгаа ч үйл ажиллагааны мэдээллийн батлагдсан маягтыг бүрэн бөглөөгүй, нотлох баримтын бүрдэл хангалтгүй байна.

1.2.5. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2019 оны 01/429 дүгээр албан бичгээр өгсөн чиглэлийн дагуу “Able soft” хэрэглээний программд суурилсан хүүхэд, гэр бүлийн мэдээллийн сангийн “Тохиргоо” цэсийн мэдээлэл авах хэсэгт хүүхэд хамгааллын чиглэлээр “Хурдан морины уралдаан”, “Асрамж, халамжийн төв”, “Хүүхэд харах үйлчилгээ”, “Хүүхдийн зуслан”, “Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдийн бүртгэл” зэрэг 5 төрлийн мэдээллийг нэгтгэдэг болсон байна.

Сэлэнгэ аймгийн хувьд хүүхэд харах үйлчилгээ, хүүхдийн зуслан болон асрамж, халамжийн төвийн чиглэлээр үйл ажиллагаа явуулаагүй тул уг программд эдгээртэй холбоотой мэдээллийг оруулаагүй бөгөөд хурдан морины уралдаан, эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдүүдийн мэдээллийг оруулан нэгдсэн сан үүсгэсэн байна.

Хурдан морины уралдааны мэдээлэл, уяачдын мэдээлэл, унаач хүүхдийн мэдээлэл гэсэн үндсэн 3 мэдээлэл / хэдэн настай хүүхэд ямар насны морь унасан, хэдэн жил уралдааны морь унаж байгаа, хэдэн төгрөгийн шан харамж авдаг, сургуулийн мэдээлэл, уралдааны явцад бэртэл, гэмтэл авч байсан эсэх, амь насны даатгалтай эсэх мэдээлэл/ -ийг бүрэн оруулсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт-1:

Он	Уралдааны тоо	Уяачийн тоо	Унаач хүүхдийн тоо
2019	8	82	41
2020	65	285	144
2021	1	388	138
2022	15	446	150

¹⁰ Хамтарсан багийн шийдвэр хурлын тэмдэглэлээр баталгаажна.Тэмдэглэлд хуралд оролцсон гишүүд гарын үсэг зурна. ...

Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн

2023	27	732	322
Нийт	116	1933	795

Программд уяачийн болон унаач хүүхдийн тоо нь оролцсон уралдаанаас шалтгаалж давхардсан тоогоор бүртгэгдэж байна.

Сумын ЗДТГ-ын нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтнүүд нь эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаарх 8 мэдээлэл /Үндсэн мэдээлэл, эрсдэлийн үнэлгээ, нөхцөл байдлын үнэлгээ, гэр бүлийн гишүүд, гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ, хамгаалал, зөрчил, гэр бүлтэй байгуулах гэрээ /-ийг бүртгэж байгаа бөгөөд 2021 оны мэдээллийг бүх сумд программд огт мэдээлээгүй бөгөөд бусад онуудад нийт 330 хүүхдийн мэдээлэл /2019 онд 87, 2020 онд 95, 2022 онд 7, 2023 онд 141/-ийг оруулсан байна. Үүнийг сумдаар ангилж, хүснэгтээр харуулбал:

Хүснэгт -2:

№	Сум	Он					Нийт
		2019	2020	2021	2022	2023	
1	Алтанбулаг				5		5
2	Баруунбүрэн	3				9	12
3	Баянгол					9	9
4	Ерөө					13	13
5	Жавхлант	1					1
6	Зүүнбүрэн	8				5	13
7	Мандал		91				91
8	Орхон					6	6
9	Орхонтуул	8					8
10	Сайхан	5				3	8
11	Сант	6	2			11	19
12	Сүхбаатар	34	1		1	3	39
13	Түшиг	6			1	43	50
14	Хушаат					12	12
15	Хүдэр	10				6	16
16	Цагааннуур	1	1			13	15
17	Шаамар	5				8	13
Нийт		87	95	-	7	141	330

Дээрх мэдээллийг үнэн зөв, бүрэн оруулсан эсэхийг аймгийн ХГБХХГ-аас хянаж, тулган баталгаажуулаагүй байна.

Аймгийн ХГБХХГ-т мэдээллийн нэгдсэн сан үүссэн боловч уг сангаас хэвлэх, файл хэлбэрээр хөрвүүлэх боломжгүй байгаагаас хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд оролцогч байгууллагууд мэдээллээ солилцох боломжгүй байна.

Хүчирхийллийн хохирогч болсон хүүхэд, насанд хүрэгчдийн мэдээлэл буюу Алтанбулаг, Мандал, Сүхбаатар сумын түр хамгаалах байрны үйлчлүүлэгчдийн мэдээллийг 2021 онд E-tuslamj мэдээллийн нэгдсэн санд оруулж, нэгтгэн ашиглаж байсан боловч уг мэдээллийн сан 2023 оны 10 дугаар сараас ажиллахгүй болсон байна.

1.2.6. Аймгийн ХГБХХГ-ын бүтэц, орон тоог 2022 он хүртэл аймгийн Засаг даргын захирамжаар баталж байсан бол 2022 оноос эхлэн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын тушаалаар баталсан байна. Үүнд:

Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн

- Аймгийн Засаг даргын 2018 оны А/401 дүгээр захирамжаар аймгийн ГБХЗХГ / тухайн үеийн нэршилээр / -ын зохион байгуулалтын 5 нэгжид 21, Мандал сумын Хүүхдийн ордон 12, Орхонтуул сумын Хүүхдийн хөгжлийн төв 3, Мандал, Сүхбаатар сумын түр хамгаалах байр тус бүр 2 зэрэг нийт 40 орон тоо,
- Аймгийн Засаг даргын 2021 оны А/221 дүгээр захирамжаар аймгийн ГБХЗХГ / тухайн үеийн нэршилээр / зохион байгуулалтын 4 нэгжид 23, Мандал сумын Хүүхдийн ордон 12, Орхонтуул сумын Хүүхдийн хөгжлийн төв 3, Мандал, Сүхбаатар сумын түр хамгаалах байр тус бүр 2 зэрэг нийт 42 орон тоо,
- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2022 оны А/62 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар аймгийн ГБХЗХГ / тухайн үеийн нэршилээр/ зохион байгуулалтын 5 нэгжид 23, Мандал сумын Хүүхдийн ордон 12, Орхонтуул сумын Хүүхдийн хөгжлийн төв 3, Мандал, Сүхбаатар сумын түр хамгаалах байрны нийгмийн ажилтан 5 зэрэг нийт 43 орон тоо гэх мэт.

Босоо тогтолцоонд шилжсэнээр тус газрын хүүхдийн хөгжил, хамгааллын нэгжийн орон тоонд өөрчлөлт ороогүй бөгөөд түр хамгаалах байрны нийгмийн ажилтны орон тоог нэмэгдүүлснээр сэтгэл зүйч /өмнө нь гэрээгээр ажиллуулж байсан/-ийг ажиллуулах боломжтой болсон байна.

Тус газрын Хүүхэд хөгжил, хамгааллын нэгж нь хүүхдийн хөгжил, хамгааллын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, хүүхдийн эрхийн улсын байцаагч, хүүхдийн хөгжил, оролцоо хариуцсан мэргэжилтэн, хүүхдийн эрх, хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтэн тус бүр 1 зэрэг нийт 4 орон тоотойгоор ажиллаж ирсэн байна.

Хүүхэд хамгааллын чиглэлээр сум, тосгоны нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн 23, Мандал сумын 9, Сүхбаатар сумын 8 багийн нийгмийн ажилтан, ерөнхий боловсролын сургуулийн 36 нийгмийн ажилтан зэрэг нийт 76 албан хаагч ажиллаж байна. /Дэлгэрэнгүйг Хавсралт 1-д харуулав./

Аудитад хамрагдаж буй 2019-2023 онуудад тус газрын батлагдсан орон тоонд 5-7 сул ажлын байр үүссэн бөгөөд эдгээрийг чиг үүрэг ойролцоо албан хаагчаар хавсран гүйцэтгүүлж ирсэн, ерөнхийдөө хүний нөөцийн дутагдалтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Бүлэг 2

Хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөлт, төсөвлөлт үр өгөөжтэй, хүүхдэд ээлтэй байж чадсан эсэх?

2019-2022 онуудад хүүхэд хамгааллын зардлын дийлэнх хувийг урьдчилан сэргийлэх ажилд зарцуулж байсан бол 2023 онд батлагдсан төсвийн 73.0 хувийг хариу үйлчилгээнд зарцуулсан байна.

2.1 Хүүхэд хамгааллын санхүүжилт хүртээмжтэй байна уу?

Нөхцөл байдлын үнэлгээ хийсэн, хариу үйлчилгээ үзүүлсэн нийгмийн ажилтан, хамтарсан багийн гишүүдэд олгох урамшууллыг тооцож, төлөвлөөгүй байна.

Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн

2.1.1. Сэлэнгэ аймгийн ХГБХХГ-ын 2019-2023 оны төсөвт үндсэн чиг үүрэгт хамаарах хүүхдийн хөгжил хамгаалал, залуучууд, гэр бүлийн хөгжил, хамгаалал зэрэг нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрүүдийн төсвийг хөтөлбөр тус бүрээр, эдийн засгийн ангиллаар бус *“Бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал”* гэсэн ангилалд бөөн дүнгээр баталсан байна.

Аймгийн ХГБХХГ-ын нийт батлагдсан төсөв, түүнд хүүхэд хамгааллын хөтөлбөрийн батлагдсан төсвийн эзлэх хувийн жинг он тус бүрээр хүснэгтлэн харуулбал:

Хүснэгт-3 /сая төгрөгөөр/:

Тайлант он	2019	2020	2021	2022	2023
Нийт батлагдсан төсөв	394.3	493.8	473.8	687.9	1,117.1
Бусдаар нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал	165.9	191.1	197.0	141.0	213.4
Үүнээс: Хүүхэд хамгааллын хөтөлбөрийн зардалд	83.9	109.0	109.9	108.4	188.6
Нийт төсөвт хүүхэд хамгаалах хөтөлбөрийн төсвийн эзлэх хувь	21.3	22.1	23.2	15.7	16.9

Дээрх хүснэгтээс харахад хүүхэд хамгааллын хөтөлбөрийн зардалд 2019-2021 онуудад нийт батлагдсан төсвийн 21.3-23.2 хувийг зарцуулахаар төсөв баталж байсан бол 2022 онд 15.7, 2023 онд 16.9 хувийг баталж, сүүлийн 2 жилд өмнөх онуудаас буурах хандлагатай болж ирсэн байна.

Энэ нь сүүлийн жилүүдэд хүүхэд хамгааллын үйлчилгээний эрэлт нэмэгдэж байгаагаас гадна бүтээгдэхүүн, үйлчилгээ, байрны урсгал зардал, цалингийн зардал гэх мэт урсгал зардлууд жил бүр өсөн нэмэгдэж байгаатай холбоотой юм.

2022 оныг хүртэл хүүхэд хамгааллын зардлыг өмнөх онуудын гүйцэтгэлд тулгуурлан төлөвлөж байсан бол 2023 оноос эхлэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн хамтарсан А/23/27 дугаар тушаалаар баталсан *“Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив”*-ыг үндэслэн төсөв, зардлыг төлөвлөсөн байна.

Дээрх хамтарсан тушаалд заасан аргачлал, нормативыг үндэслэн хүүхэд хамгааллын 2023 оны төсвийн төслийг дараах ангиллаар нийт 190.0 сая төгрөгөөр төсөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс 188.6 сая төгрөгөөр эцэслэн батлагдсан байна. Үүнд:

- *Шуурхай тусламжийн үйлчилгээнд 10.5 сая төгрөгийг зарцуулахаар төсвийн төсөл хүргүүлснээс 4.5 сая төгрөгөөр,*
- *Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээнд 45.9 сая төгрөгийн төсвийн төсөл хүргүүлснээс 133.1 сая төгрөгөөр,*
- *Урьдчилан сэргийлэх үйлчилгээнд 133.6 сая төгрөгийн төсөл хүргүүлснээс 51.0 сая төгрөгөөр гэх мэт.*

Өөрөөр хэлбэл 2023 онд хүүхэд хамгаалалд чиглэсэн сургалт, хөгжил буюу урьдчилан сэргийлэх үйлчилгээнд нийт төсвийн 27.0 хувь болох 51.0 сая төгрөгийг, хариу үйлчилгээ буюу шуурхай тусламжийн үйлчилгээ, хамгаалах нөхөн сэргээх

Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн үйлчилгээний зардалд 73.0 хувь болох 137.6 сая төгрөгийг тус тус зарцуулахаар эцэслэн батлагдсан байна.

Бид аудитын явцад “Хүүхдийн хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив”-ын 1.2 дахь заалтын дагуу өмнөх оны цахим мэдээллийн сан дахь кейсийн тоонд үндэслэн давтан тооцоолол хийж шалгахад 2023 онд хүүхэд хамгааллын дээрх түвшний үйлчилгээнд нийт 169.2 сая төгрөг зарцуулахаар тооцогдсон болно.

Гэтэл аймгийн ХГБХХГ нь 2023 оны төсвийн төслийг боловсруулахдаа Хүүхэд хамгааллын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.6-д заасан нэмэгдэл урамшууллыг тооцолгүйгээр тохиолдлын тоог өмнөх мэдээллийн сангаас хэт нэмэгдүүлэн, нийт зардлыг 190.0 сая төгрөгөөр тооцож, төсвийн төслийн санал хүргүүлснийг 188.6 сая төгрөгөөр эцэслэн баталсан байна.

Өөрөөр хэлбэл 2023 онд дээрх хуулийн 12 дугаар зүйлийн 12.6-д заасан нөхцөл байдлын үнэлгээ хийсэн, хариу үйлчилгээ үзүүлсэн нийгмийн ажилтан, хамтарсан багийн гишүүнд олгох **27.3 сая** төгрөгийн /өмнөх оны тохиолдлын тоогоор тооцов/ нэмэгдэл, урамшууллыг тооцож, төлөвлөөгүй байна.

2.1.2. 2019-2022 онуудад шуурхай тусламжийн үйлчилгээний болон хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний зардлыг нэгтгэж, урьдчилан сэргийлэх үйлчилгээний зардлыг салгаж төлөвлөж байсан бол 2023 оноос эхлэн дээрх 3 ангилал тус бүрээр төсвийг төлөвлөсөн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт-4 /сая төгрөгөөр/:

Зардлын ангилал	Шуурхай тусламжийн үйлчилгээний зардал	Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний зардал	Урьдчилан сэргийлэх үйлчилгээний зардал	Нийт батлагдсан төсөв	Нийт ХХ-ын төсөвт урьдчилан сэргийлэх үйлчилгээний эзлэх хувь
2019		33.6	50.3	83.9	60.0
2020		43.6	65.4	109.0	60.0
2021		44.0	65.9	109.9	60.0
2022		43.4	65.0	108.4	60.0
2023	4.5	133.1	51.0	188.6	27.0
Нийт батлагдсан төсөв	4.5	297.7	297.6	599.8	49.6

2019-2022 онуудад урьдчилан сэргийлэх үйлчилгээнд нийт зардлын 60.0 хувийг, хариу үйлчилгээнд 40.0 хувийг зарцуулах бодлого барьж, төсвийг төлөвлөж байсан бол 2023 онд хариу үйлчилгээнд илүү төсөв батлах бодлого барьсан байна.

Аудитын дүнгээс харахад жил бүр хүүхэд хамгааллын төсвийг нэмэгдүүлэн баталж байгаа боловч хүчирхийлэлд өртсөн, эрх нь зөрчигдсөн хүүхдийн тоо буурахгүй байгаа нь хүүхэд хүчирхийлэлд өртсөний дараа бус хүчирхийлэл гарахаас урьдчилан сэргийлэх, хүчирхийллийг эрт илрүүлэх, хамгаалах үйл ажиллагаанд төсвийг чиглүүлж, эрсдэлт гэр бүл болон олон нийтэд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлыг сайжруулах нь зүйтэй гэж үзэж байна.

2.1.3. Хүүхэд хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулах төсвийг дээрх бүлгүүдэд дурдсанчлан өмнөх оны гүйцэтгэл, тохиолдлын тоонд үндэслэн холбогдох журмаар тогтоосон үйлчилгээний зардлын нормативаар тооцож, төлөвлөж ирсэн байна.

Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 -т *“Засаг даргын өргөн мэдүүлснээр харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардал, нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны урсгал зардал, хамтарсан багийн үйл ажиллагааны зардал, хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон зардлыг тухайн орон нутгийн төсөвт тусган батлах, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх”, 19 дүгээр зүйлийн 19.1.3-т “орон нутгийн төсвийн хөрөнгөөр нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр байгуулах саналаа иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах” гэж заасан байдаг.*

Энэхүү заалтын дагуу аймгийн ХГБХХГ-ын 2023 оны 139 дүгээр албан бичгээр Сүхбаатар сумын түр хамгаалах байрны орон тоог нэмэгдүүлэх саналыг аймгийн ИТХ-ын даргад хүргүүлсэн байна.

Уг саналын дагуу 2023 оны 12 дугаар сараас эхлэн Сүхбаатар сумын түр хамгаалах байрны тогооч, үйлчлэгчийн цалинг олгож эхэлсэн боловч Мандал сум дахь түр хамгаалах байрны орон тоог нэмэгдүүлээгүй байна.

Мандал сум дахь түр хамгаалах байрны үйл ажиллагаа нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/116 дугаар тушаалаар баталсан *“Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журам”-ын 5 дугаар зүйлд заасны дагуу үйлчилгээ үзүүлэх ёстой боловч хүн ам, гэмт хэргийн гаралт ихтэйгээс шалтгаалан батлагдсан орон тооны 2 нийгмийн ажилтан /тогооч, үйлчлэгчийн ажлыг давхар гүйцэтгэдэг/ ачаалалтай ажиллаж байна.*

Хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд зориулан улс, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн зардлыг бүрэн олгож байгаа ч зарим шаардлагатай орон тоо, түүний цалинг төсөвт тусган баталж, хэрэгжүүлээгүй байна.

2.2 Хүүхэд хамгаалалд төлөвлөсөн санхүүжилтийн гүйцэтгэл үр дүнтэй, хяналттай байна уу?

Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээнд батлагдсан төсвийг урьдчилан сэргийлэх ажилд гүйлгэн зарцуулсан боловч гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.

2.2.1. Аудитад хамрагдаж буй 2019-2023 онуудад хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд нийт 599.8 сая төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 590.3 сая төгрөг зарцуулан батлагдсан төсвийг 9.5 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн

Хүснэгт-5 /сая төгрөгөөр/:

Зардлын ангилал	2019			2020			2021			2022			2023		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Шуурхай тусламжийн үйлчилгээний зардал											6.5		4.5	4.5	-
Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний зардал	33.6	33.6	-	43.6	43.6	-	44.0	44.0	-	43.4	36.8	(0.1)	133.1	133.1	-
Урьдчилан сэргийлэх үйлчилгээний зардал	50.3	50.3	-	65.4	65.1	(0.3)	65.9	56.9	(9.0)	65.0	65.0	-	51.0	50.9	(0.1)
Нийт зарцуулалт	83.9	83.9	-	109.0	108.7	(0.3)	109.9	100.9	(9.0)	108.4	108.3	(0.1)	188.6	188.5	(0.1)

Батлагдсан төсвийн зарцуулалтыг анхан шатны баримт, материалтай тулган шалгахад зардлын арга хэмжээ хооронд гүйлгэн зарцуулсан боловч гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй **9.5 сая** төгрөгийн дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- 2022 онд хамгаалал, нөхөн сэргээх үйлчилгээний зардлаас “Зорилтот бүлгийн 30 өрхөд багц ” зэрэг 5 арга хэмжээнд буюу урьдчилан сэргийлэх зардалд 6.6 сая төгрөгийг гүйлгэн зарцуулсан,
- 2023 онд хүүхэд хамгаалал, нөхөн сэргээх үйлчилгээний зардлаас “Сурагчийн аюулгүй байдал нөлөөллийн ажил” гэсэн арга хэмжээнд буюу урьдчилан сэргийлэх үйлчилгээний зардалд 2.9 сая төгрөгийг гүйлгэн зарцуулсан боловч гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.

Хамтарсан багийн үйл ажиллагаанд олгосон санхүүжилтийг нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт болон 108 дугаарт ирсэн дуудлага мэдээллийн дагуу нөхцөл байдлын үнэлгээ хийсэн тоотой тулган шалгахад ХНХ-ын сайд, Сангийн сайдын 2022 оны А/23/27 дугаар хамтарсан тушаалыг хэрэгжүүлэн, шуурхай тусламж үйлчилгээний зардлаас 2022 онд 113 хүүхдэд 4.8 сая төгрөг, 2023 онд 229 хүүхдэд 7.7 сая төгрөг зэрэг нийт 342 хүүхдэд 12.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дүгээр зүйлийн 18.1.6¹¹-д зааснаар хамтарсан багт 8 удаа, эцэг эх, хүүхдэд 45 зэрэг нийт 53 удаагийн сургалтыг зохион байгуулж, нийт 98.7 сая төгрөгийг зарцуулсан байна. Дэлгэрэнгүйг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт-6:

Сургалтын тоо		2019	2020	2021	2022	2023	Нийт
Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулахад	Хамтарсан багийн гишүүд	201	117	267	106	40	731
	Зарцуулсан зардал /сая төгрөгөөр/	1.4	6.1	4.0	3.9	2.2	17.6
Сургалт	Эцэг эх, асран хамгаалагч	1213	240	2782	3303	3842	11380
	Хүүхэд	1735	423	1643	2051	2597	8449
	Зарцуулсан зардал /сая төгрөгөөр/	9.0	29.6	11.3	9.8	21.4	81.1
Нийт сургалтын үйл ажиллагаанд зарцуулсан зардал /сая төгрөгөөр/		10.4	35.7	15.3	13.7	23.6	98.7

¹¹ хүүхдийг гэр бүл, нийгмийн бүх орчинд эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах

Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-т “Хохирогчид үзүүлэх аюулгүй байдлын хамгаалалтын үйлчилгээ дараах хэлбэртэй байна”, 34.1.1-т “Түр хамгаалах байр”, 35 дугаар зүйлийн 35.2-т “Түр хамгаалах байрыг төрийн, төрийн бус байгууллагын харьяанд, сум, аймаг, дүүрэг, нийслэлийн нутаг дэвсгэрийн харьяаллаар байгуулан ажиллуулж болно” гэж заасан байдаг.

Тус заалтын дагуу 2018 онд Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Мандал сумдад түр хамгаалах байр ажиллуулж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/116 дугаар тушаалаар баталсан “Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журам”-ын 9 дүгээр зүйлийн дагуу улс, орон нутгийн төсвөөс 2019-2023 онуудад олгосон санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байна. Үүнд:

- Урсгал зардалд улсын төсвөөс 225.0 сая төгрөг,
- Тогтмол зардалд орон нутгийн төсвөөс 50.4 сая төгрөг гэх мэт.

2022 онд Хууль зүй, дотоод хэргийн яам, Азийн хөгжлийн банк хамтран “Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төсөл”-ийн хүрээнд 301.0 сая төгрөгийн санхүүжилттэйгээр Сүхбаатар суманд түр хамгаалах байр барьсан байна.

Тус байр баригдсанаар 2023 оны 11 дүгээр сар хүртэлх хугацаанд Алтанбулаг суманд үйл ажиллагаа явуулж байсан түр хамгаалах байрыг тус байранд шилжүүлэн ажиллуулж, урсгал зардалд 2.1 сая төгрөг, тогтмол зардал болон тогооч, үйлчлэгчийн цалинд 1.6 сая төгрөг олгосныг зориулалтын дагуу зарцуулсан байна.

2.2.2 Хүүхэд хамгааллын үйл ажиллагааны батлагдсан төсөв, түүний зарцуулалтын ил тод байдал, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, дараах мэдээллүүдийг шилэн дансны цахим хуудсанд бүрэн мэдээлсэн байна. Үүнд:

- Хүүхэд хамгааллын үйл ажиллагааны төсвийн зарцуулалтыг батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлт хэсэгт,
- 2022 онд гүйцэтгэгдсэн 5.1 сая төгрөгийн нөлөөллийн ажил, арга хэмжээний зардлыг 5.0 сая төгрөгөөс дээших орлого, зарлагын мэдээлэл хэсэгт,
- Хандив тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан хэсэгт нийт 55.0 сая төгрөгийн 8 удаагийн мэдээллийг мэдээлсэн байна.

Хүүхэд хамгааллын зардлыг Шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн байдлыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт-7:

№	Мэдээллийн төрөл	2019		2020		2021		2022		2023	
		Тоо	Дүн /сая төгрөгөөр/	Тоо	Дүн /сая төгрөгөөр/	Тоо	Дүн /сая төгрөгөөр/	Тоо	Дүн /сая төгрөгөөр/	Тоо	Дүн /сая төгрөгөөр/
1	Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлт	30	83.9	30	108.7	30	100.9	30	108.3	36	188.5
2	Хандив тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан	1	-	1	13.7	1	15.7	1	8.6	4	17.0
Нийт мэдээлсэн дүн		31	83.9	31	122.4	31	116.6	31	116.9	40	205.5

Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн

Мөн хүүхэд хамгааллын зардын төлөвлөгөө, гүйцэтгэл, хэрэгжилтийг байгууллагын ил тодын самбарт бүрэн мэдээлж, төсвийн ил тод байдлыг хангаж ажилласан байна.

2.2.3. Аудитад хамрагдаж буй 2019-2023 онд Азийн хөгжлийн банк, Европын холбоо, Швейцарын хөгжлийн агентлаг, Япон улсын Ядуурлыг бууруулах сан, Дэлхийн зөн Монгол ОУБ-ын Сэлэнгэ орон нутгийн хөгжлийн хөтөлбөр зэрэг олон улсын байгууллагуудын нийт 60.1 сая төгрөгийн санхүүжилтээр дараах төслүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

2020 онд Азийн хөгжлийн банк, ХЗДХЯ-ны хамтарсан 13.7 сая төгрөгийн санхүүжилтээр “Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” төслийн хүрээнд Мандал суман дахь түр хамгаалах байрыг засаж, тохижуулсан,

2021 онд Европын холбоо, Швейцарын хөгжлийн агентлагийн 15.3 сая төгрөгийн санхүүжилтээр “Хүүхдийн бэлгийн хүчирхийллийг зогсооё” төслийг хүрээнд Мандал суман дахь Түр хамгаалах байрны сэтгэл зүйн зөвлөгөө өгөх өрөөг засаж, тохижуулсан, Дэлхийн зөн Монгол ОУБ-ын Сэлэнгэ орон нутгийн хөгжлийн хөтөлбөрийн 0.4 сая төгрөгийн санхүүжилтээр тус хамгаалах байранд үйлчлүүлэгчдийн хувийн хэргийг хадгалах төмөр сейф худалдан авсан,

2022 онд Азийн хөгжлийн банкны 12.4 сая төгрөгийн санхүүжилтээр “Эрүүл хүүхэд” төслийн хүрээнд Мандал суман дахь Түр хамгаалах байрны эмчийн үзлэгийн өрөөг засаж, тохижуулсан, Япон улсын Ядуурлыг бууруулах сангийн 5.0 сая төгрөгийн санхүүжилтээр “Эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг дэмжих” төслийн хүрээнд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 10 эмэгтэйд буцалтгүй тусламж үзүүлсэн,

2023 онд Дэлхийн зөн Монгол ОУБ-ын Сэлэнгэ орон нутгийн хөгжлийн хөтөлбөрийн 13.3 сая төгрөгийн санхүүжилтээр аймгийн ХГБХХГ-ын насанд хүрээгүй хохирогчоос мэдүүлэг авах, уулзалт хийх өрөөг засаж, тохижуулсан байна.

Тайлант онуудад хэрэгжүүлсэн төслийн явц болон хэрэгжилтийг санхүүжүүлэгч байгууллагаас хэрхэн хянаж, баталгаажуулсан талаар холбогдох мэргэжилтнээс асуулга, тодруулга авахад хяналтын тайланг зөвхөн захиалагч байгууллагад хүргүүлэн, хэрэгжүүлэгч байгууллагад ямар нэгэн тайлан мэдээ хүргүүлээгүй, хөрөнгийн зарцуулалтад хяналт, шалгалт хийгдээгүй байна.

2.2.4. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д заасан нөхцөлд байгаа хүүхдүүдэд хүүхэд хамгааллын дараах цогц үйлчилгээг үзүүлж, тэдгээрийн үйл ажиллагаанд төсвөөс олгох санхүүжилтийг холбогдох, журам, аргачлал, нормативын дагуу төлөвлөж, зарцуулсан байна. Үүнд:

- Шуурхай тусламжийн,
- Хамгаалах, нөхөн сэргээх,
- Урьдчилан сэргийлэх гэх мэт.

Дээрх цогц үйлчилгээний төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн талаар тайлангийн 2 дугаар бүлэгт, харин эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдэд үзүүлсэн хүүхэд хамгааллын цогц үйлчилгээ, түүний үр дүнгийн талаар тайлангийн 1, 3 дугаар бүлгүүдэд дэлгэрэнгүйгээр дурдсан болно.

Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн

2.2.5. Аймгийн ХГБХХГ-ын хүүхдийн нууцтай танилцах, харилцах эрх бүхий албан тушаалтнууд нь холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд нь нийт 168 удаагийн нууцын гэрээ гарган ажилласан байна.

Аймаг болон сумын хамтарсан багийн гишүүд, Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүд хүүхэдтэй хамааралтай хэлэлцүүлэг хийх тухай бүр тухайн хүүхдийн хувийн мэдээллийг задруулахгүй байх нууцын баталгаа гаргаж ирсэн байна.

Харин аудитын явцад түүвэрлэн 7 сургуулийн дотуур байрны үйл ажиллагааг “Шалгах хуудас”-аар авсан асуулгын дүнг нэгтгэн үзэхэд зарим сургууль нь албан хаагчтай байгуулсан хөдөлмөрийн гэрээнд хүүхдийн хувийн нууцыг чандлан хадгалах үүргийг тусгаагүй байгаа нь хүүхдийн хувийн нууцлал алдагдах эрсдэлтэй байгааг харуулж байна.

Засгийн газрын 2017оны 246 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам”-ын 10.9 дахь “Нууц баримт бичиг, бусад тээгчийг зориулалтын сейф, төмөр шүүгээ, тусгай агуулах, хайрцагт хадгална” гэж заасан байдаг.

Дээрх журмын 6.7¹² дахь заалтын дагуу албан хаагчдын хэрэглэж буй компьютер болон программын хамгаалалтыг тулган шалгахад компьютер бүрийг кодолсон, хүүхдийн зөрчилтэй холбоотой мэдээллийг бүртгэдэг программ хангамжийг системийн хэмжээнд нууцлалтай хандах эрхийн зөвшөөрлөөр нэвтэрч байна.

Аудитын явцад нууцыг хэрхэн хадгалж, хамгаалж буйд ажиглалт хийж шалгахад аймгийн ХГБХХГ нь Дэлхийн зөн монгол ОУБ-аас 2021 онд хандивын санхүүжилтийн эх үүсвэрээр олгосон зориулалтын 2 төмөр сейфт хүүхдийн эрхийн улсын байцаагч болон хүүхдийн эрх хамгааллын мэргэжилтэн нь зөрчлийн кейсүүдийг 75 ширхэг архивын нэгж үүсгэн хадгалж байна.

Харин аудитын явцад Сүхбаатар сумын 8 багийн хамтарсан багуудаас “Шалгах хуудас”-аар авсан асуулгын дүнг нэгтгэн үзэхэд зөрчлийн тохиолдол, баримт, материалыг хадгалах зориулалтын сейф байхгүй, түгжээтэй шүүгээнд хадгалж байна гэж хариулсан буюу энэ нь хамтарсан багуудад нууцлалын асуудал, түүнд зориулсан санхүүжилт хангалтгүй байгааг харуулж байна.

Аймгийн ХГБХХГ нь 2020 онд төсвийн хөрөнгөөр 15.3 сая төгрөгийн үнэ бүхий 9 зөөврийн компьютерыг худалдан авч албан хаагчдыг хэрэгцээ, шаардлагад нийцсэн техник хэрэгслээр хангасан байна.

2.2.6 Хүүхэд хамгааллын зардлын гүйцэтгэлд урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны болон хариу үйлчилгээний зардлын гүйцэтгэлийн эзлэх хувийн жинг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт-8 /сая төгрөгөөр/

Хүүхэд хамгааллын зардал	2019 он		2020 он		2021 он		2022 он		2023 он	
	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн
Хариу үйлчилгээ	40.1	33.6	40.1	43.6	43.6	44.0	40.0	43.3	73.0	137.6

¹² “Нууц мэдээлэл агуулж байгаа компьютер болон зөөврийн дискэнд эрх бүхий албан тушаалтнаас өөр этгээд хандахаас урьдчилан сэргийлэх зорилгоор тэдгээрийг шифрлэн бэлтгэх, нээж ашиглахад биометр мэдээлэл, эсхүл цахим түлхүүр, нууц өгүүлбэр бүхий хамгаалалтын арга хэлбэрийг хэрэглэнэ”

Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн

Урьдчилан сэргийлэх ажил	59.9	50.3	59.9	65.1	56.4	56.9	60.0	65.0	27.0	50.9
Хүүхэд хамгаалалд батлагдсан төсөв	100.0	83.9	100.0	108.7	100.0	100.9	100.0	108.3	100.0	188.5

Хүснэгтээс харахад 2019-2022 онуудад хүүхэд хамгааллын зардлын төсвийн 50.3-65.1 хувийг урьдчилан сэргийлэх ажилд зарцуулсан бол 2023 онд 27.0 хувь буюу 50.9 сая төгрөгийг урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд, 73.0 хувийг буюу 137.6 сая төгрөгийг хариу үйлчилгээнд зарцуулсан байна.

Өөрөөр хэлбэл 2019-2022 онуудад хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх ажлыг чухалчлан үзэж төсвийг түлхүү байдлаар хуваарилан зарцуулж байсан бол 2023 оноос эхлэн хариу үйлчилгээнд ач холбогдол өгч, төсвийн 73.0 хувийг зарцуулсан байна.

Бүлэг 3

Хүүхэд хамгааллын талаар баримталж буй бодлогын хэрэгжилт үр дүнтэй байна уу?

Хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд оролцогч талуудын хэрэгжүүлж буй үйл ажиллагааг нэгтгэх, үнэлэх ажил хангалтгүй байна.

3.1 Хүүхэд хамгааллын талаар хэрэгжиж буй үйл ажиллагаанд тавих хяналтын тогтолцоо үр дүнтэй ажиллаж байна уу?

Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөл нь хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.1.1 Хүүхэд хамгааллын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.4-т “Хүүхэд хамгаалалд төрийн байгууллагуудын оролцоог үнэлэх” гэж заасан байдаг. Гэвч холбогдох байгууллагаас хүүхдийн эрхийг хамгаалахад чиглэгдсэн оролцогч талуудын үйл ажиллагааг үнэлж, дүгнэх салбарын онцлогт нийцсэн шалгуур үзүүлэлт, нарийвчилсан аргачлалыг боловсруулж, батлуулаагүй байна.

3.1.2 Хүүхэд хамгааллын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д “Хүүхэд хамгааллын нөхцөл байдлыг тодорхойлох, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд үзүүлэх хариу үйлчилгээг үнэлэх зорилгоор **хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага** нь дараах хяналт, шинжилгээ, үнэлгээ хийнэ” гэж заасан байдаг.

Аймгийн ХГБХХГ нь хуульд заагдсан дээрх 7 төрлийн чиг үүргээс байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд дараах чиглэлээр хяналт, шинжилгээ хийхээр тусгаж, хэрэгжилтийг хангаж, тайлагнасан байна. Үүнд:

- Эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхдүүдийн мэдээллийг анхан шатанд ажиллаж буй хамтарсан багуудаас жил бүр авч хүүхдийн эрсдэлийн үнэлгээг хийж, программд оруулан мэдээллийн сан үүсгэснээр хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг үзүүлсэн,

Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн

- *Хууль зөрчсөн, гэмт хэргийн гэрч, хохирогч болсон хүүхдийн талаар бүртгэл судалгааг хууль сахиулах байгууллагуудтай хамтран гаргаж, гэмт хэрэгт холбогдсон 2, хохирогч 10, гэмт хэргийн сэжигтэн 1, албадлагын арга хэмжээ авагдсан 7 зэрэг нийт 12 хүүхдэд хариу үйлчилгээ үзүүлсэн гэх мэт.*

Харин аудитын тайлангийн 3.1.1-д дурдсан аргачлал, шалгуур үзүүлэлтийг боловсруулж хэрэгжүүлээгүйгээс хуульд заасан бусад чиглэлийн хяналт үнэлгээ болох төрийн байгууллагуудын оролцоо, сургалтын чанар, үр нөлөө, захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтийг үнэлэх ажлууд хийгдээгүй байна.

3.1.3 Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 01/94 дүгээр албан бичгээр НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос Монгол Улсын 5 дугаар тайлан илтгэлд өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг ирүүлэхийг чиглэл болгосон байна.

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1¹³-д заасны дагуу аймгийн ГБХЗХГ /*тухайн үеийн нэршлээр*/ -аас НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос Монгол Улсын 5 дугаар тайлан илтгэлд өгсөн зөвлөмжийг хэрэгжилтийг 32 үзүүлэлтээр гаргаж, дунджаар 94.8 хувийн биелэлтэй тайлагнасан байна.

Аудитын явцад зөвлөмжийн биелэлтийг холбогдох баримт бичгүүдтэй тулган шалгахад дараах асуудлуудыг зөрүүтэй тайлагнасан зөрчил илэрлээ. Үүнд:

- *Эрсдэлт нөхцөлд байгаа 2019 онд 600, 2020 онд 751, 2021 онд 751 хүүхдийг эрсдэлийн программд бүрэн мэдээлсэн гэж 90.0 хувьтай үнэлсэн боловч аудитын явцад программд нийт 330 хүүхэд бүртгэлтэй байна,*
- *Аймаг, сумдын Хүүхдийн төлөө зөвлөл нь 15 удаа хуралдсан гэж 90.0 хувьтай үнэлсэн боловч аймгийн Хүүхдийн төлөө зөвлөл нь зөвхөн 2023 онд нэг удаа хуралдсан байна.*

Дээрхээс үзэхэд НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцын 5 дугаар тайланд өгсөн зөвлөмжийн биелэлтийг үнэн зөв, бодитоор тайлагнаагүй байна.

3.1.4 Аудитад хамрагдаж буй 2019-2023 онд Сэлэнгэ аймагт хүүхэд хамгааллын чиглэлээр олон улсын байгууллага болон төрийн бус байгууллагаас тусгайлсан хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

Харин Азийн хөгжлийн банк, Европын холбоо, Швейцарын хөгжлийн агентлаг, Япон улсын Ядуурлыг бууруулах сан, Дэлхийн зөн Монгол ОУБ зэрэг улсын хэмжээнд хэрэгжиж буй тайлангийн 2.2.3-т дурдсан тохижилт, засварын ажлуудыг хийж, гүйцэтгэсэн боловч эдгээрийн үр дүнг тооцож, нэгтгэн дүгнээгүй байна.

3.1.5 Хүүхэд хамгааллын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *“Монгол Улсын хэмжээнд Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл, орон нутагт хүүхдийн Хүүхдийн төлөө зөвлөл нь хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт тавина.”* гэж зохицуулсан байдаг.

¹³ Монгол Улс олон улсын гэрээнд заасны дагуу Олон Улсын төрөлжсөн байгууллага /Нэгдсэн Үндэсний байгууллага, түүний салбар байгууллага/-д Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн талаар үндсэн тайланг заасан хугацаанд төрийн байгууллагаас хүргүүлэх бөгөөд хүүхэд, олон нийт, нийгмийн оролцоотой гаргана.

Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн

Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 03 дугаар тогтоолоор “Хүүхэд хамгааллын бодлого”-ыг баталсан байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2020 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/240 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар “Хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”, хоёрдугаар хавсралтаар “Хүүхдийн эрхийн ажилтны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”, гуравдугаар хавсралтаар “Хүүхдийн элчийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”-ийг тус тус баталж, эдгээр аргачлалын дагуу жил бүрийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дараа оны 02 дугаар сарын 15-ны дотор ирүүлэхийг Хүүхдийн төлөө зөвлөлийн ажлын албаны дарга нарт үүрэг болгосон байна.

Дээр дурдсанчлан холбогдох байгууллагуудаас “Хүүхэд хамгааллын бодлого”, түүнийг хэрэгжүүлэгч байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, үнэлэх аргачлалыг боловсруулж хүргүүлсэн боловч Хүүхдийн төлөө зөвлөлийн ажлын алба болох аймгийн ХГБХХГ нь “Хүүхдийн эрхийн ажилтны 2019-2023 оны үйл ажиллагаа”-нд хяналт-шинжилгээ, үнэлгээ огт хийгээгүй, аймаг, сумдын Хүүхдийн төлөө зөвлөл, Хүүхдийн элчийн 2021 оны үйл ажиллагаанд 1 удаа л дараах байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байна. Үүнд:

- Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааг 65.0 хувь буюу “Хангалтгүй” гэж үнэлж, дүгнэсэн,
- Баруунбүрэн, Баянгол, Түшиг, Цагааннуур зэрэг 4 сумын Хүүхдийн төлөө зөвлөл нь 2021 үйл ажиллагааны тайланг ирүүлээгүй тул хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдээгүй,
- Ерөө, Зүүнбүрэн, Жавхлант, Орхон, Орхонтуул, Сүхбаатар зэрэг 5 сумын Хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагааг “Хангалттай” гэж үнэлсэн бол бусад 8 сумын Хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагааг “Сайжруулах шаардлагатай” гэж үнэлж, дүгнэсэн,
- Шаамар сумаас бусад 16 сумын “Хүүхдийн элч”-ийн үйл ажиллагааг 5 оноо бүхий 9 үзүүлэлтээр дүгнэж нийт 36 оноо буюу 80.0 хувь, сумын Засаг даргын зүгээс Хүүхдийн элчийн үйл ажиллагааг дэмжих талаар авсан арга хэмжээний хэрэгжилтийг 65.0 хувиар тус тус үнэлж, дүгнэсэн байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2020 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн А/217 дугаар тушаалаар баталсан “Түр хамгаалах байрны үйлчилгээ, үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх удирдамж”-ийн дагуу түр хамгаалах байрны үйл ажиллагаа, үйлчилгээнд 2020, 2023 онд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дараах байдлаар үнэлсэн байна. Үүнд:

- 2020 онд Мандал суман дахь Түр хамгаалах байрны үйл ажиллагааг 97.7 хувь, Алтанбулаг суман дахь Түр хамгаалах байрны үйл ажиллагааг 80.0 хувиар,
- 2023 онд Мандал суман дахь Түр хамгаалах байрны үйлчилгээ, үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн бөгөөд үйл ажиллагааг 93.7, үйлчилгээг 90 хувиар гэх мэт.

Дээр дурдсанчлан Хүүхэд хамгааллын бодлогын 2021 оны хэрэгжилтийн үнэлгээгээр хангалтгүй үнэлэгдсэн аймгийн болон 8 сумын Хүүхдийн төлөө


Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн зөвлөлийн үйл ажиллагааг Хүүхдийн төлөө зөвлөлийн дүрмийн 3.2¹⁴-т заасны дагуу зөвлөлийн хурлаар хэлэлцэж, цаашид авах арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх үйл ажиллагаа огт хийгдээгүй байна.

3.1.6 Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/110 дугаар тушаалаар “Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх үлгэрчилсэн заавар”-ыг баталсан боловч уг үлгэрчилсэн зааврыг үндэслэн бодлогын баримт бичгийн үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт, аргачлалыг боловсруулж, мөрдөөгүй байна.

3.1.7 Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт, аргачлалыг боловсруулаагүй боловч Засгийн газрын 2002 оны 245 дугаар тогтоолоор баталсан “Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр”, 2017 оны 270 дугаар тогтоолоор баталсан “Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэн ажиллаж, хэрэгжилтийг тайлагнасан байна. /Тайлангийн 1.1.6-д дэлгэрэнгүйгээр дурдав/

Аудитын явцад 920 иргэнээс авсан санал асуулгаар “Хүүхэд хамгааллын үйл ажиллагааны үр дүнг та хэрхэн дүгнэж байна вэ?” гэсэн асуултад нийт оролцогчдын 28.2 хувь буюу 259 иргэн **муу**, 47.4 хувь буюу 436 иргэн **дунд** гэж үнэлсэн бол 24.4 хувь буюу 225 иргэн **маш сайн**, **сайн** гэж үнэлсэн байна. Уг үнэлгээг дүрслэлээр харуулбал:

Дүрслэл-1:



Өөрөөр хэлбэл санал асуулгад оролцсон нийт иргэдийн дийлэнх нь хүүхэд хамгааллын үйл ажиллагааны үр дүнг “Дунд” гэж үнэлсэн байна.

3.2 Хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлж буй арга хэмжээ нь салбар бүрд эерэг өөрчлөлт бий болгож байна уу?

Зарим салбарт хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт хангалтгүй байна.

¹⁴ Хүүхдийн эрхийг хангах, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалал, хөгжлийн талаар төрөөс баримтлах бодлого, үндсэн чиглэл, түүний хэрэгжилт, үр дүнг хэлэлцэх.

Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн

3.2.1 Хүүхэд хамгааллын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1¹⁵-д “Гэр бүл дэх хүүхэд хамгаалал”-ын асуудлыг зохицуулсан бол Гэр бүлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2-т эцэг эхийн хүлээх үүргийн талаар тусгасан байдаг.

Аудитад хамрагдсан 2019-2023 онуудад аймгийн ХГБХХГ-аас хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга, гэр бүлийн боловсрол олгох чиглэлээр 8 удаагийн модуль сургалтуудад давхардсан тоогоор нийт 30980 иргэнд сургалт зохион байгуулсан байна.


Хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд өсөж, хөгжих нөхцөлийг бүрдүүлэхийн тулд Хөдөлмөрийн тухай хууль /2022 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс мөрдөгдөж эхэлсэн./-ийн 43 дугаар зүйлийн 43.3-т¹⁶ ажил олгогчийн зүгээс ажилтны хүүхдэд ээлтэй, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхээр заасан бол Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 03-ний өдрийн 03 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар “Байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэд эцэг, эхийн зөвлөл байгуулж ажиллуулах зөвлөмж”-ийг баталсан байдаг.

Аудитад хамрагдаж буй 2019-2023 онд нийт 130 байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагын шийдвэрээр “Байгууллагын дэргэдэх эцэг, эхийн зөвлөл”-ийг байгуулан үйл ажиллагаагаа явуулсан байна.

Байгууллагууд ажилтны хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх зорилгоор хүүхдийн өрөөтэй болгосон бөгөөд 2022 онд 2, 2023 онд 8 байгууллага шинээр хүүхдийн өрөөтэй болж, тохижуулсан байна.

Мөн хүүхдэд аливаа эрсдэл, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх сургалт арга хэмжээ болон тэмдэглэлт өдрүүдээр нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулснаар хүүхэд болзошгүй эрсдэлээс өөрийгөө хамгаалах талаар ойлголттой болсон гэж дүгнэсэн байна.

Дүрслэл-2:



Дүрслэлээс өөрийн гэр бүлийн орчинд эрх нь зөрчигдсөн хүүхдийн тоо 2021 онд 78 байсан бол 2022 онд 166, 2023 онд 155 болж өссөн байна.

Өөрөөр хэлбэл аймгийн ХГБХХГ-аас эцэг, эхийн зөвлөлтэй хамтран гэр бүл дэх хүүхэд хамгааллын чиглэлээр урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж байгаа хэдий ч үр дүнг үнэлэх, дүн шинжилгээ хийгдэх ажил

¹⁵ Эцэг, эх, гэр бүлийн гишүүд, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхэдтэй холбоотой эрх, үүргээ урвуулан ашиглах, хүүхдийг үл хайхрах, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэр, аливаа гэмт хэрэг, зөрчлөөс хамгаалах арга хэмжээ авна.

¹⁶ Ажил олгогч нь ажил, амралтын цагийг зохицуулах, хөдөлмөр эрхлэлтийн уян хатан нөхцөл хэрэглэх зэргээр ажилтны ажил, амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгах замаар ажилтны хүүхдэд ээлтэй, хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлнэ.

Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн хийгдээгүй бөгөөд гэр бүлийн орчинд хүүхдийн эрх зөрчигдсөн тохиолдол жил ирэх бүр нэмэгдсэн байна.

3.2.2 Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1¹⁷-д заасны дагуу Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/476 дугаар тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь Хүүхэд хамгааллын бодлого”-ыг баталсан байна.

Дээрх бодлогын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд сумдын ИТХ-ын тогтоолоор ерөнхий боловсролын 36 сургуульд “Хүүхэд хамгааллын баг”-ийг байгуулсан байна.

Аудитын явцад Сүхбаатар сумын 7 сургуулийн “Хүүхэд хамгааллын баг”-ийн үйл ажиллагааг түүвэрлэн авч үзэхэд сургуулийн хүүхэд хамгааллын төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг тайлагнаагүй, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг судлан тогтоох, бүртгэх, эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээг хийгээгүй зэрэг зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Сүхбаатар сумын сургуулиудын “Хүүхэд хамгааллын баг” нь аудитад хамрагдаж буй онуудын хүүхдийн хөгжил, хамгааллын төлөвлөгөөг боловсруулж, батлаагүй, /1 болон 5 дугаар сургууль нь 2019-2021 оны , 2, 3, 6 дугаар сургуулиуд нь 2019-2022 оны , Спортын сургууль нь 2020, 2021 оны гэх мэт/,
- Дээрх 7 сургууль нь хүүхэд хамгааллын төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлж болохуйц хэлбэрээр бус, фото зураг бүхий хэлбэрээр тайлагнасан байгаа нь нийт хэдэн арга хэмжээг төлөвлөж, биелэлт хэдэн хувьтай байгаа зэргийг үнэлж, дүгнэх боломжгүй байна,
- Сүхбаатар сумын 2 дугаар сургууль нь 2019-2022, 3 дугаар сургууль нь 2019-2020, 6 дугаар сургууль нь 2019-2021 онуудад эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг судлан тогтоох, бүртгэх, эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээг хийгээгүй байна.

Аймгийн ХГБХХГ-ын хүүхдийн эрхийн улсын байцаагч нь ИТХ-ын ГХУСАЗЗ, БШУГ, МХГ-тай хамтран 2022 онд Сүхбаатар сумаас бусад 16 сумын сургууль, цэцэрлэг, сургуулийн дотуур байранд хүүхэд хамгааллын үйл ажиллагаа хэрхэн хийгдэж байгаад хяналт шалгалтыг хэрэгжүүлснээр тайлагнасан байна. Тус хяналт шалгалтаар дараах нийтлэг зөрчлүүд гарсан байна. Үүнд:

- Сургуулиудын “Хүүхэд хамгааллын баг” нь үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан боловч биелэлтийн тайлан гаргаагүй, хэрэгжүүлсэн арга хэмжээгээ үнэлж, дүгнэдэггүй, сар бүр хуралддаггүй, тохиолдлын хувийн хэргийг нээж, баяжилт хийдэггүй,
- Сургуулийн орчин, дотуур байранд хүүхдийн аюулгүй байдлыг хангаж, шатны тэмдэг тэмдэглэгээ байршуулаагүй, анги танхимын цахилгааны утас, багшийн эргэн тойронд байгаа цахилгааны утас эмх цэгцгүй, эрсдэлтэй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй,
- Хүчирхийлэлд өртсөн болон сэтгэл зүйн үйлчилгээ авах шаардлагатай хүүхдүүдийг сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйчид холбон зуучлах арга хэмжээг зохион байгуулаагүй гэх мэт.

Аудитын явцад 7 сургуулийн дотуур байрны үйл ажиллагааг түүвэрлэн “Шалгах хуудас”-аар дүгнэн, дүнг нэгтгэн үзэхэд зарим сургуулиудын дотуур байрны хяналтын камер нь бичлэгийг 1 сарын хугацаанд бус 7 хоногийн хугацаанд хадгалж байгаа бол

¹⁷ Сургалтын байгууллага хүүхэд хамгааллын бодлогыг тухайн байгууллагад хэрэгжүүлэхдээ хөтөлбөр, төлөвлөгөө гарган мөрдөж ажиллана.

Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн

2 дотуур байр нь эцэг, эхийн уулзалтын өрөөгүй байна. Энэ нь “ЕБС-ийн дотуур байрын орчин, үйлчилгээ MNS 6781:2019” стандартын 5.2.10, 9.9 дэх заалтуудтай нийцэхгүй байна.

Дээрхээс үзэхэд боловсролын салбар нь үйл ажиллагаандаа хүүхэд хамгааллын бодлогыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, үр дүнг үнэлээгүй, дүн шинжилгээ хийгээгүй байна.

3.2.3 Хүүхэд хамгааллын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т “Эрүүл мэндийн байгууллага эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хуульд заасны дагуу үзүүлнэ.” гэж заасан бөгөөд Эрүүл мэндийн сайдын 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/151 дүгээр тушаалаар “Хүчирхийлэлд өртсөн хүүхэд, өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх заавар”-ыг баталсан байна.

Эрүүл мэндийн байгууллагууд нь 2019 онд 6, 2020 онд 8, 2021 онд 7, 2022 онд 9, 2023 онд 23 зэрэг нийт 53 эрсдэлт бүлгийн хүүхдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хуульд заасны дагуу үзүүлсэн байна.

Аймгийн ХГБХХГ нь 2019-2023 онд аймгийн Нэгдсэн эмнэлэг, Эмнэх өрхийн ЭМТ-тай хамтран хүүхэд хамгааллын чиглэлээр 4 удаагийн сургалт, 6 төрлийн урьдчилан сэргийлэх болон эрүүл мэндийн үзлэгт давхардсан тоогоор 12,555 хүүхдийг хамруулснаар тайлагнасан байна.

Аудитад хамрагдсан 2019-2022 онуудад хүүхдийн тусламжийн 108 утас болон өргөдөл гомдлоор, Засгийн газрын олон нийттэй харилцах 1111 төвд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаарх гомдол мэдээлэл бүртгэгдээгүй бол 2023 онд хохирогч хүүхдийн 1 гомдол, мэдээлэл ирсний дагуу хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлж бүрэн шийдвэрлэсэн байна.

Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд эрүүл мэндийн тусламжийг тухай бүр үзүүлж байгаа хэдий ч хүчирхийлэлд өртсөн хүүхдийг олон нийтийн хараанд өртүүлэхгүйгээр тусгай нөхцөлд үйлчлүүлэх боломжоор хангаагүйгээс нууцлал алдагдах эрсдэлтэй байна.

3.2.4 Хүүхэд хамгааллын тухай хуулийн 8 дугаар зүйлд “Хэвлэл, мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгаалал”-ын харилцааг зохицуулсан байдаг.

2019-2023 онд хэвлэл, мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгааллын чиглэлээр аймгийн Цагдаагийн газраас дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Зарын групп байршуулсан насанд хүрээгүй хүүхдийн нэр төрд халдсан байж болзошгүй мэдээллүүдийг устгаж, мэдээлэлтэй холбоотой хүүхдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр ерөнхий боловсролын сургуулиудад албан шаардлага хүргүүлсэн,
- Кибер аюулгүй байдал хариуцсан мөрдөгч болон хүүхдийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн нар хамтран ерөнхий боловсролын сургуулиудын нийгмийн ажилтнуудад цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгсөн,

Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн

- Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй хандалт өндөртэй зарын групп болон цахим хаягуудад кибер аюулгүй байдлын чиглэл хариуцсан эрүүгийн мөрдөгч хяналт тавин ажиллаж, хүүхдийн нэр төр, алдар хүндэд халдах, гутаан доромжлох, залилах, хүчирхийлэл, садар самуунд уриалах зэрэг үйл ажиллагааг тохиолдол бүрд устгах чиглэлийг админуудад өгсөн,
- 2023 онд насанд хүрээгүй 2 хүүхэд хохирогчоор тогтоогдсон 2 гэмт хэрэг бүртгэгдсэнийг Эрүүгийн цагдаагийн албаны Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэст шилжүүлсэн байна.

Дээрх ажлуудыг хийж гүйцэтгэснээр хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчин дахь хүүхэд хамгаалал хангагдсан байна.

3.2.5 Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлд Олон нийтийн арга хэмжээ, үйлчилгээн дэх хүүхэд хамгаалал, 9¹ дүгээр зүйлд Соёл, спортын үйл ажиллагаан дахь хүүхэд хамгааллын асуудлыг зохицуулсан байдаг.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9^{1.4}¹⁸-т заасны дагуу аймгийн ГБХЗХГ /тухайн үеийн нэршилээр/, Соёл урлагийн газрын даргын хамтарсан 2022 оны 12 дугаар сарын 07-ын өдрийн А/242/А/76 дугаар тушаалаар “Соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах журам”-ыг баталсан байна.

Дээрх журмыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн ХГБХХГ-аас 2023 онд аймгийн Биеийн тамир, спортын газрын багш дасгалжуулагч, Соёл урлагийн газрын мэргэжилтэн, соёлын төвийн эрхлэгч, мэргэжилтэн зэрэг 179 албан хаагчид дээрх журмыг танилцуулах сургалтыг зохион байгуулсан байна. Үүний хүрээнд Сэлэнгэ аймагт 2023 онд зохион байгуулагдсан улс, аймгийн чанартай олон нийтийн арга хэмжээнүүдэд оролцсон 6102 хүүхдийн асран хамгаалагч 162 багш, дасгалжуулагчтай 3 талт хариуцлагын гэрээг улсын хэмжээнд анх удаа байгуулсан байна.

Гэвч 2024 онд дээрх журмыг зөрчиж соёл урлагийн үйл ажиллагаанд эцэг эхээс зөвшөөрөлгүйгээр хүүхэд оролцуулсан, хариуцлагын гэрээ байгуулаагүй, гэнэтийн ослын даатгалд хамруулаагүй зэргээс хүүхдийн эрх зөрчигдөн авто тээврийн осолд өртөж, эрүүл мэнд нь ноцтой хохирсон тохиолдол бүртгэгдсэн байна.

Олон нийтийн арга хэмжээ, соёл, спортын үйл ажиллагааны үеэр хүүхдийн тусламжийн 108 утсанд 2021 онд 4, 2022 онд 16, 2023 онд 20 зэрэг нийт 40 хүүхэд /2019, 2020 онд хүүхдийн эрх зөрчигдсэн тохиолдол гараагүй байна./ -ийн эрх зөрчигдсэн дуудлага бүртгэгдсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт-9:

№	Хүүхдийн эрх зөрчигдсэн байдал	Он					Нийт
		2019	2020	2021	2022	2023	
1	Үе тэнгийн дээрэлхэлтэд өртсөн	*	*	2	5	8	15
2	Хүүхдийн тэвчишгүй хөдөлмөр эрхэлсэн	*	*	1	3	5	9
3	Сөрөг зан үйлийн хүчирхийлэлд өртсөн	*	*	*	5	3	8

¹⁸Соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах журмыг соёлын болон хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага баталж, мөрдүүлнэ.

Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн

4	Үл хайхрах хүчирхийлэлд өртсөн	*	*	*	3	3	6
5	Хувийн техник хэрэгслээр зорчиж яваад алга болсон	*	*	1	*	1	2
Нийт		*	*	4	16	20	40

Дээр дурдсанчлан хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, нөлөөллийн ажлууд хийгдсээр байгаа ч олон нийт, соёлын арга хэмжээнд хүүхэд хамгаалал бүрэн хангагдахгүй байна.

3.2.6 Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан аюулт үзэгдэл, осол болон олон нийтийг хамарсан жагсаал, цуглаан, эмх замбараагүй байдал зэрэг онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, тусламж, дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор Засгийн газрын 2019 оны 201 дүгээр тогтоолоор “Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, тусламж дэмжлэг үзүүлэх журам”-ыг баталсан байна.

Дээрх журмын 2.9.3¹⁹-т заасны дагуу аймгийн ХГБХХГ-ын даргын / тухайн үеийн нэршилээр / 2019 оны А/77 дугаар тушаалаар “Хүүхэд хамгааллын мэргэжлийн анги”-ийн бүрэлдэхүүн, бүтэц зохион байгуулалтыг анх баталсан бол 2022 оны А/35 дугаар тушаалаар бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан байна.

Аймгийн ХГБХХГ / тухайн үеийн нэршилээр / нь 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдөр “Хүүхэд хамгааллын мэргэжлийн анги”-ийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулж, аймгийн ОБГ-ын гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтнээр батлуулсан байна.

Аудитад хамрагдаж буй 2020-2023 онд гамшиг, онцгой нөхцөл байдлын үед дээрх анги нь нийт 761 зорилтот өрхийн 3025 хүүхдэд дараах чиглэлээр хариу үйлчилгээ үзүүлсэн байна. Үүнд:

- Эцэг, эх нь хөл хорионд орсон, асран хамгаалагчгүй 32 өрхийн 63 хүүхдэд хүнс, ахуйн дэмжлэг, иргэд олон нийтийн хандив тусламжаар ковидын тасагт хэвтэж эмчлүүлсэн 42 хүүхдэд болон зорилтот бүлгийн 884 хүүхдэд хүнс, ахуйн багц, амин дэмийн дэмжлэг үзүүлсэн,
- Ширүүн борооны улмаас үерт өртсөн Ерөө, Баянгол, Мандал, Шаамар сум, Дулаанхаан тосгоны 166 өрхийн 240 хүүхдэд хичээлийн хэрэгслэлийн дэмжлэг үзүүлсэн гэх мэт

Аудитад хамрагдаж буй 2019-2023 онуудад гамшиг, гамшигийн онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрх зөрчигдсөн болон хүүхэд хамгааллын талаарх гомдол, мэдээлэл бүртгэгдээгүй байна.

3.3 Хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа нь үр дүнтэй байж чадаж байна уу?

Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байгаа хэдий ч хүүхдийн эсрэг гэмт хэргийн тоо нөлөөлөхүйцээр буурахгүй, бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоо 2023 онд өмнөх оноос бараг 5 дахин өссөн байна.

¹⁹ Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага дараах үүрэг хүлээнэ: 2.9.3.хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийн үүрэг гүйцэтгэх

3.3.1 Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8-д “Хүүхдийн эрхийн чиглэлээр гадаадын болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах” гэж заасан байдаг.

НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1989 онд Хүүхдийн эрхийн тухай Конвенцын соёрхон баталсан бөгөөд Монгол Улс уг Конвенцод 1990 онд нэгдэн орсон байна.

НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцийн 5 дугаар тайланд өгсөн дүгнэлт, зөвлөмжийн хүрээнд хүүхдийн эрх хамгааллын асуудлыг салбар дундын зохицуулалтаар хууль эрх зүйг боловсронгуй болгож, Хүүхдийн эрхийн тухай хууль /2 журам/, Хүүхэд хамгааллын тухай хууль /7 журам, 1 стандарт/, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль /20 журам 1 стандарт/ , Гэр бүлийн тухай хууль /1 журам/-ийг мөрдөн ажилласан байна.

Аймгийн ХГБХХГ-аас дээрх хууль, журмыг хэрэгжүүлэн, холбогдох тайлан, мэдээг жил бүр гарган, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна.

3.3.2 Хүүхэд хамгааллын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2²⁰-т заасны дагуу Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2014 оны 01 дүгээр тогтоолыг үндэслэн ХТҮГ /тухайн үеийн нэршилээр/-ын даргын 2014 оны Б/49 дүгээр тушаалаар хүүхэд хамгааллын шуурхай тусламж, үйлчилгээний тогтолцоог хөгжүүлэх зорилгоор “108 хүүхдийн тусламжийн утас”-ыг ажиллуулж эхэлсэн байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар /тухайн үеийн нэршилээр/ -ын даргын 2018 оны А/259 дүгээр тушаалаар “Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвийн дуудлага хүлээн авах, шилжүүлэх, ашиглах үйлчилгээ үзүүлэх журам”-ыг баталсан байна.

Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв нь 24 цагаар, үнэ төлбөргүйгээр ирсэн дуудлага бүрийг хүлээн авч, хүүхэдтэй холбоотой бүх мэдээллийг бүртгэлийн программд оруулан агуулгаар нь “Хүүхэд хамгаалал”, “Хүүхдийн эрхийн зөрчил”, “Чимээгүй”, “Зөвлөгөө”, “Мэдээлэл”, “Зорилтот бус” /андуурсан, тоглосон, тасарсан/ гэж ангилагдан бүртгэгдэж ирсэн байна.

Аудитад хамрагдаж буй 2019 онд 96, 2020 онд 159, 2021 онд 198, 2022 онд 242, 2023 онд 252 зэрэг нийт 947 дуудлага бүртгэгдсэнийг төрлөөр нь хүснэгтээр харуулбал:

Хүснэгт -10:

№	Хүүхэд хүчирхийлэлд өртсөн төрөл	Он, хүүхдийн тоо					Нийт
		2019	2020	2021	2022	2023	
1	Бие махбодын хүчирхийлэлд өртсөн	20	55	53	56	67	251
2	Бэлгийн хүчирхийлэлд өртсөн	13	1	7	9	5	35
3	Үл хайхрах хүчирхийлэлд өртсөн	24	51	61	53	59	248
4	Сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн	17	21	39	74	78	229
5	Бусад	22	31	38	50	43	184

²⁰ Энэ зүйлд заасан мэдээ, мэдээллийг хүлээн авах, илрүүлэх зорилгоор яаралтай тусламжийн 24 цагийн утас ажиллуулж болно.

Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн

	Нийт	96	159	198	242	252	947
	Дуудлага мэдээллийг шийдвэрлэсэн байдал /хувиар/	96.9	96.8	99.8	100	100	98.9

Хүснэгтээс харахад 2019 онд 96 дуудлагаас 3, 2020 онд 159 дуудлагаас 5, 2021 онд 198 дуудлагаас 2-ыг нь тус тус он дамжуулан шийдвэрлэсэн бол 2022, 2023 оны нийт 494 дуудлагыг бүрэн шийдвэрлэж, кейсийн мэдээллийг мэдээлсэн байна.

Нэг талаас хүүхдийн эрх зөрчигдсөн дуудлага мэдээлэл жил бүр өсөх хандлагатай харагдаж байгаа ч нөгөө талаас урьдчилан сэргийлэх, нөлөөллийн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулснаар далд хэлбэрт байсан хүүхдийн эсрэг хүчирхийллийн илрүүлэлт нэмэгдсэн байх талтай юм.

Аудитаар хүүхдийн тусламжийн 108 утасны тусгай программд нэвтэрч дуудлага, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, шаардлагатай арга хэмжээ авсан эсэхийг тулган шалгахад дараах байдалтай байна. Үүнд:

- 2019-2023 онуудад бүртгэгдсэн 947 дуудлага мэдээллийг аймгийн ХГБХХГ-ын мэргэжилтэн дүн шинжилгээ хийж, хамтарсан багт 793, хүүхдийн эрхийн улсын байцаагчид 154 дуудлага, мэдээллийг тус шилжүүлж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажилласан байна. Үүний дагуу “Хамтарсан баг” эрсдэлийн үнэлгээг хийснээр тухайн дуудлага, мэдээлэлд ажиллах төлөвлөлтийг хийж, хүүхдийн зөрчигдсөн эрхийг арилгуулсан байна.
- Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн чиг үүргийн хүрээнд Зөрчлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.20.7²¹-д заасны дагуу 2019 онд 1, 2020 онд 2, 2021 онд 1, 2022 онд 1, 2023 онд 11 гомдол мэдээллийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлснээр эрсдэлийг бууруулсан байна.

Өөрөөр хэлбэл 108 утсанд ирсэн дуудлага, мэдээллийг тухай бүр шийдвэрлэж, хариу арга хэмжээ авсан байна.

3.3.3 Аймгийн ХГБХХГ-аас Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1²²-д заасан 6 чиглэлийн дагуу эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдэд хүүхэд хамгаалах хариу үйлчилгээ үзүүлж ирсэн байна.

Тухайлбал, аудитад хамрагдсан хугацаанд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйлчилгээг үзүүлэх шаардлага үүсээгүй бол дундаас дээш эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдийн эрсдэлийг үнэлж, нөхцөл байдлын үнэлгээ хийх, дэмжих, холбон зуучлах, гэр бүлд нь эргэн нэгтгэх үйлчилгээг үзүүлж, 2019 оноос бусад онуудын нотлох баримтыг архивын нэгж болгон хадгалсан байна. Үүнд:

- 2020 онд нөхцөл байдлын үнэлгээг 751 хүүхдэд, үүнээс өндөр болон дунд эрсдэл бүхий 349 хүүхдийг дэмжих, холбон зуучлах, 86 хүүхдийг гэр бүлд эргэн нэгтгэх үйлчилгээг үзүүлсэн,

²¹ Хүүхдийн бие махбодод халдсан, эсхүл үл хайхарсан, эсхүл хүүхдийн дэргэд архиан согтуурсан, мансуурсан, хүчирхийлэл үйлдсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

²² Эрсдэлт нөхцөлд байгаа, гэмт хэргийн хохирогч болсон, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, ял шийтгүүлж байгаа, албадлагын арга хэмжээ авагдсан, сургалт хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан хүүхдийг нийгэмд хэвийн амьдрахад нь тусалж, дэмжих чиглэлээр дараах хариу үйлчилгээ үзүүлнэ: 10.1.1.мэдээлэл хүлээн авах, илрүүлэх, шалгах, 10.1.2.нөхцөл байдлын үнэлгээ хийх, 10.1.3.аюулгүй байдлыг хангах, 10.1.4.дэмжих, холбон зуучлах, 10.1.5.хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйлчилгээ үзүүлэх, 10.1.6.гэр бүлд нь эргэн нэгтгэх.

Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн


- 2021 онд нөхцөл байдлын үнэлгээг 751 хүүхдэд, үүнээс өндөр болон дунд эрсдэл бүхий 444 хүүхдийг дэмжих, холбон зуучлах, 9 хүүхдийг гэр бүлд эргэн нэгтгэх үйлчилгээг үзүүлсэн,
- 2022 онд нөхцөл байдлын үнэлгээг 590 хүүхдэд, үүнээс өндөр болон дунд эрсдэл бүхий 255 хүүхдийг дэмжих, холбон зуучлах, 4 хүүхдийг гэр бүлд эргэн нэгтгэх үйлчилгээг үзүүлсэн,
- 2023 онд нөхцөл байдлын үнэлгээг 609 хүүхдэд, үүнээс өндөр болон дунд эрсдэл бүхий 486 хүүхдийг дэмжих, холбон зуучлах, 7 хүүхдийг гэр бүлд эргэн нэгтгэх үйлчилгээг үзүүлсэн байна.

Аудитын явцад Сүхбаатар суман дахь Түр хамгаалах байрны үйлчлүүлэгчдийн хувийн хэрэг болон сэтгэл зүйчийн зөвлөгөө өгсөн тэмдэглэлийг тулгахад үл хайхрах хүчирхийлэлд өртсөн 40, бие махбодын хүчирхийлэлд өртсөн 18, бэлгийн хүчирхийлэлд өртсөн 7, сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн 5 зэрэг нийт 70 хүүхдэд сэтгэл зүйн зөвлөгөөг үнэ төлбөргүй үзүүлсэн байна.

Аудитын явцад аймгийн ХГБХХГ-ын хүүхдийн эрхийн улсын байцаагчаас тодруулахад: “Эцэг, эх, асран хамгаалагч нарын зүгээс хүүхдэд тавих хараа хяналт сул, гэр бүл салат, архидалт, ажилгүйдэл зэрэг нь хүүхдийн эсрэг гэмт хэргийн суурь шалтгаан болж гэмт хэрэг өсөхөд нөлөөлж байна” гэсэн тайлбар өгсөн болно.

Аудитын явцад 920 иргэнээс цахим хэлбэрээр авсан санал асуулгын дүнг дүрслэлээр харуулбал:

Дүрслэл -3:



“Хүүхдийн тусламж үйлчилгээг шуурхай үзүүлж байна уу?” гэсэн асуултад оролцогчдын 27.1 хувь маш сайн, сайн гэж дүгнэсэн бол 22.9 хувь нь муу, 50.0 хувь нь дунд гэж хариулсан байна.

Харин “Таны бодлоор хүүхэд хамгааллын чиглэлээр урьдчилан сэргийлэх үйлчилгээ хангалттай ажиллаж байна уу?” гэсэн асуултад оролцогчдын 51.8 хувь нь маш сайн, сайн гэж дүгнэсэн бол 27.5 хувь нь муу, 20.7 хувь нь дунд гэж хариулсан байна.

Өөрөөр хэлбэл тусламж үйлчилгээнд иргэдийн сэтгэл ханамж “дунд” байдаг бол хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд “сайн” байна.

Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн

3.3.4 Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, ХЗДХ-ийн сайд нарын 2021 оны А/190/А/280 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам”-ын 5 дугаар зүйлийн 5.10-т “ *Ажлын алба нь хууль зөрчсөн хүүхдийн мэдээллийг бүртгэх, мэдээлэх, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тогтоож түүнийг арилгах, дахин гаргахгүй байх арга хэмжээг авах талаар орон нутаг дахь төрийн захиргааны болон хуулийн байгууллагуудтай хамтран ажиллана*” гэж заасан байдаг.

Аймгийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны 2022, 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд Ажлын алба нь Цагдаагийн газар болон ШШГГ-тай хамтран гэмт хэрэг үйлдсэн, зөрчил гаргасан хүүхдийг дахин гэмт хэрэг үйлдэх, зөрчил урьдчилан сэргийлэх ажлыг төлөвлөн, хэрэгжилтийг нь тайлагнасан байна.

Аудитад хамрагдаж буй 2019-2023 онд бүртгэгдсэн насанд хүрээгүй хүүхдийн эсрэг гэмт хэргийн тоон мэдээллийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт-11:

№	Үзүүлэлт	Он				
		2019	2020	2021	2022	2023
1	Гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийн тоо	78	37	41	53	54
2	Гэмт хэргийн улмаас нас барсан хүүхдийн тоо	9	8	6	3	4
3	Гэмт хэргийн улмаас гэмтсэн хүүхдийн тоо	16	14	27	28	17
4	Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоо	40	13	9	5	24
5	Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоо	*	40	11	58	48
6	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон хүүхэд	*	5	11	7	6
7	Амиа хорлож нас барсан хүүхдийн тоо	9	11	3	*	1

Эх сурвалж: Аймгийн ХГБХХГ-ын 2019-2023 оны статистик мэдээ

Хэдийгээр Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооноос хүүхдийн эсрэг гэмт хэргийн суурь шалтгааныг судалж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байгаа хэдий ч хүүхдийн эсрэг гэмт хэргийн тоо нөлөөлөхүйцээр буурахгүй, ялангуяа бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоо 2023 онд өмнөх оноос бараг 5 дахин өссөн байна.

3.3.5 Хүүхэд хамгааллын статистик үзүүлэлтийн ойлголт, тодорхойлолтыг олон улсын арга зүйтэй нийцүүлэх, бүх түвшний хэрэглэгчдийг нэгдсэн арга зүй, тоон мэдээллээр хангах зорилгоор Үндэсний статистикийн хорооны даргын 2015 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/145 дугаар тушаалаар “Хүүхэд хамгааллын статистикийн үзүүлэлт тооцох аргачлал”-ыг баталсан байна.

Дээрх аргачлалын дагуу хүүхдийн боловсролын 23, эрүүл мэндийн 31, аж байдлын 16, нийгмийн хамгааллын 44, өсөн хүмүүжиж байгаа орчны 15 зэрэг нийт 5 бүлэг, 129 үзүүлэлтээр статистик мэдээллийг гаргаж байна.

Аудитад хамрагдаж буй 2019-2023 онд аймгийн ХГБХХГ нь дээрх мэдээний маягтын дагуу салбар бүрээс мэдээллийг авч нэгтгэн, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газарт цахим хэлбэрээр тухай бүр хүргүүлсэн гэх боловч гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулаагүй, архивын нэгж болгон хадгалаагүй байна.

Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн

Аймгийн ХГБХХГ нь хүүхэд хамгааллын статистик мэдээллийн дүн, нөхцөл байдлыг Хүүхдийн төлөө зөвлөл, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороонд танилцуулаагүй, тоон үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийгээгүй

ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ

Аудитаар илэрсэн нийт **36.8** сая төгрөгийн зөрчлийг арилгах, цаашид давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв. Үүнд:

- Нөхцөл байдлын үнэлгээ хийсэн, хариу үйлчилгээ үзүүлсэн нийгмийн ажилтан, хамтарсан багийн гишүүнд олгох **27.3 сая** төгрөгийн */өмнөх оны тохиолдлын тоогоор тооцов/* урамшууллыг тооцож, төлөвлөөгүй,
- Хариу үйлчилгээний батлагдсан төсвөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд нийт 9.5 сая төгрөгийг гүйлгэн зарцуулсан.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээг аймгийн хөгжлийн дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусган хэрэгжүүлсэн байна.
- Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөл нь холбогдох хууль, журмын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байгаа хэдий ч түүний “Ажлын алба” болох ХГБХХГ-ын ажлын уялдаа холбоо, өдөр тутмын үйл ажиллагаа хангалтгүй байна.
- Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөл, хүүхэд хамгааллын үйл ажиллагааны нөхцөл байдалд үр нөлөө бүхий хяналт шинжилгээ, үнэлгээ тогтмол хийгдээгүй байна.
- Хүүхдийн эсрэг гэмт хэргийн суурь шалтгааныг судалж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байгаа хэдий ч хүүхдийн эсрэг гэмт хэргийн тоо нөлөөлөхүйцээр буурахгүй, ялангуяа бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоо 2023 онд өмнөх оноос бараг 5 дахин өссөн байна
- Гэр бүлийн орчинд эрх нь зөрчигдсөн хүүхдийн тоо 2021 онд 78 байсан бол 2022 онд 166, 2023 онд 155 болж өссөн байна.
- 2019-2022 онуудад хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төсвийн дийлэнхийг төлөвлөн зарцуулж байсан бол 2023 онд батлагдсан төсвийн 27.0 хувийг зарцуулсан байна.
- Хүүхэд хамгааллын төсөвт нөхцөл байдлын үнэлгээ хийсэн, хариу үйлчилгээ үзүүлсэн нийгмийн ажилтан, хамтарсан багийн гишүүнд олгох урамшууллыг тооцож, төсвийг иж бүрэн төлөвлөөгүй байна.
- Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний батлагдсан төсвөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.

ЗӨВЛӨМЖ

Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймаг, сумдын Засаг дарга бөгөөд Хүүхдийн төлөө зөвлөлийн дарга нарт:

- Алсын хараа 2050, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулах замаар Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөгжлийн жилийн төлөвлөгөөнд хүүхэд хамгааллын үр нөлөө бүхий асуудлыг төлөвлөж, хэрэгжилтийг ханган, үнэн зөв тайлагнаж байх.
- Хүүхдийн төлөө зөвлөлийг нэгдсэн удирдлагаар ханган, үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, дүн шинжилгээ хийх замаар цаашид хэрэгжүүлэх үр нөлөө бүхий бодлого, шийдвэрийг тодорхойлж, үйл ажиллагааг тогтмолжуулах.
- Хүүхэд хамгааллын салбар дундын зохицуулалтыг ханган дэмжих, хэрэгжилтийг хангах, хүүхэд хамгааллын үр нөлөө бүхий арга хэмжээг хэрэгжүүлсний үндсэн дээр хүүхдийн эрх зөрчигдөх, хүүхдийн эсрэг, хүчирхийллийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх.

Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга П.Оюун-д:

- Холбогдох хууль, журмыг хэрэгжүүлэх замаар аймгийн Хүүхдийн төлөө зөвлөл, Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны "Ажлын алба"-ны үйл ажиллагааг сайжруулж, холбогдох мэдээ, тайлан, төлөвлөгөөг баталгаажуулан архивын нэгж болгон хадгалах.
- Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөл, хүүхэд хамгааллын үйл ажиллагааны нөхцөл байдалд хяналт шинжилгээ хийж, бодит үнэлэлт дүгнэлт өгсний үндсэн дээр цаашид хэрэгжүүлэх үр нөлөө бүхий арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх.
- "Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив"-ыг баримтлах замаар хүүхэд хамгааллын төсөвт нөхцөл байдлын үнэлгээ хийсэн, хариу үйлчилгээ үзүүлсэн нийгмийн ажилтан, хамтарсан багийн гишүүнд олгох урамшууллыг тооцож, төсвийг иж бүрэн төлөвлөх.
- Хүүхэд хамгаалах байрны хэрэгцээ шаардлага, орон тоо, төсвийг тооцоо судалгаан дээр үндэслэж бодитоор төлөвлөх замаар үйл ажиллагаа явуулах хэвийн нөхцөлөөр хангах.
- Төсвийн зарцуулалтад холбогдох хууль, журмыг хэрэгжүүлэх замаар хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх болон хариу үйлчилгээний батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, үнэн зөв тайлагнах.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

Б.БАТМӨНХ

С.БААСАНСҮРЭН

Ж.ЦОГТ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ
ХАМГААЛЛЫН ГАЗРААС ИРҮҮЛСЭН САНАЛ**



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ,
ХАМГААЛЛЫН ГАЗАР**

447 тоот, 4-р гудамж, Их суварга, 6-р баг
Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976) 7036-2269
Цахим шуудан: selenge@fcy.gov.mn
Цахим хуудас: selenge.fcy.gov.mn

2024.10.22 № 205
танай _____-ны № _____

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

“Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй
бодлого, түүний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн
гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайлантай холбоотой санал, хүсэлтгүй болно.

ДАРГА



П.ОЮУН

Doc.jijig blank

4339030065